**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН**
**2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

***Тайланг хянасан:*** ***Төсвийн ерөнхийлөн захирагч***

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ ......................... В.МӨНХБАТ

.........................
(огноо)

***Тайлагнасан:*** ***Төсвийн Шууд захирагч***

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА ......................... Ц.БАДРАХ

.........................

(огноо)

***Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:*** ***Нэгжийн дарга***

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА ......................... Б.ЛХАГВАСҮРЭН

.........................
(огноо)

## БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ТОВЧОО

| № | Үндсэн чиг үүрэг буюу дэд салбарын нэр | Зорилтын тоо | Арга хэмжээний тоо | Зорилтын дундаж хувь |
|---|---|---|---|---|
| 1 | Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх чиглэлээр | 14 | 34 | 81.9 |
| 2 | Хууль, эрх зүй | 5 | 7 | 97 |
| 3 | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар | 17 | 37 | 86.2 |
| 4 | Санхүү, төсвийн талаар | 4 | 9 | 96.2 |
| 5 | Нийгмийн бодлогын чиглэлээр | 10 | 17 | 86.3 |
| 6 | Хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар | 1 | 12 | 97.5 |
| 7 | Батлан хамгаалах чиглэлээр | 1 | 4 | 100 |
| **Нийт** | | | | **91,2** |

## БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /сая.төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хагас жил | Жилийн эцэс | | |
| НЭГ. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР | | | | | | | | |
| АХЖТ-ний зорилго 4.1. Төрийн захиргааны байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, эрх мэдлийн зааг, ялгааг оновчтой тодорхойлж, төр хувийн хэвшлийн оролцоог зохистой хангасан тогтолцоог бий болгоно. | | | | | | | | |
| **Зорилт 1.1** | **Байгууллагын бүтэц, орон тоог шинэчлэн батлах** | - | Бүтэц, орон тоог шинэчлэн баталсан байдал | 0 | Бүтэц, орон тоог шинэчлэн батална | - | Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын тушаалаар ЗГ-н 377 дугаар тогтоолд нийцүүлэн бүтэц орон тоог шинэчлэн баталсан. | **100** |
| 1.1.1 | Чиг үүргийн шинжилгээ хийх | - | Чиг үүргийн шинжилгээ хийж, удирдлагад танилцуулсан байдал | 0 | Чиг үүргийн шинжилгээ хийж ажлын давхардал, хийдлийг тогтооно | - | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн чиг үүргийн тухайд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын чиг үүргийг хариуцсан бие даасан мэргэжилтэн ажиллуулах нь зүйтэй, мөн одоо байгаа бүтцэд аймгийн ерөнхий архитектор, дэд бүтцийн асуудлыг 2 мэргэжилтэн тус тусдаа хариуцан ажиллаж байгааг дэд бүтцийн асуудлыг бүхэлд нь нэг ажлын байранд хамааруулж албан тушаалын тодорхойлотод тусгах нь оновчтой байна.<br>1. Одоо ТЗУХ-т байгаа мэдээллийн технологийн асуудал хариуцсан ажлын байрыг Төрийн үйлчилгээ-мэдээллийн нэгдсэн төвд шилжүүлж, түүнээс гадна төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн чиг үүрэг, аймгийн болон агентлаг, сумдын веб сайт гэх мэт чиг үүргийг бүхэлд нь тус Төрийн үйлчилгээ - мэдээллийн төвд хариуцуулж ажлын чиг үүргийг тогтоон орон тоог нэмж зохион байгуулах<br>2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс Дотоод аудитын чиг үүрэг нь хасагдаж Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс болсон тул Дотоод | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | аудитын чиг үүргийг Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтсийн чиг үүрэгт нэмж зохих бүтцийн өөрчлөлтийг хийх Аймгийн архивын ажлын ачааллыг харгалзан тус тасагт нэг архивч нэмэх саналтай, Төрийн албаны салбар зөвлөлийн орон тооны нарийн бичгийн даргын орон тоог тусад нь батлуулах нь зүйтэй гэж тус тус дүгнэв. | |
| 1.1.2 | Зарим Төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолт боловсруулж, Төрийн албаны зөвлөлөөр хянуулах | - | Шинээр болон шинэчлэн боловсруулсан албан тушаалын тодорхойлолтын тоо | 0 | 5 | - | 24 | 100 |
| 1.1.3 | Хэлтсүүдийн дүрмийг шинэчлэн батлах | - | Дүрэм шинэчлэн баталсан байдал | 0 | Хэлтсүүдийн саналыг аван дүрмийг шинэчлэн баталсан байна | - | Засгийн газрын 2021 оны “Аймгийн засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” 377 дугаар тогтоолын хүрээнд Аймгийн Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тоо шинэчлэн батлагдаж хэлтсүүдийн дүрэмд өөрчлөлт оруулан 2022 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн А/08 тушаалаар баталсан. | 100 |
| **Зорилт 1.2** | **Сумдын Засаг даргын тамгын газрын бүтэц, чиг үүргийг оновчтой зохион байгуулах талаар арга хэмжэ хэрэгжүүлэх** | - | Зөвлөмж, чиглэл хүргүүлсэн тоо | 0 | Сумдын Засаг даргын тамгын газрын бүтэц зохион байгуулалт сайжирна | - | Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан бичгээр 2022 оны 03 дугаар сард чиглэл хүргүүлж ажилласан. | **100** |
| 1.2.1 | Сумдын Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлуулах талаар зөвлөмж, чиглэл хүргүүлэх | - | Зөвлөмж, чиглэл хүргүүлсэн тоо | 0 | 1 | - | Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль шинээр мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотой сумдын Засаг даргын тамгын газрын дарга нарт байгууллагын бүтээз шинэчлэн батлах, батлахдаа мэргэжилтэн, албан хаагчдын батлагдсан албан тушаалын тодорхойлолтын нэр нэршлийг нэг мөр хэрэглэх талаар албан бичгээр зөвлөмж хүргүүлж, цахим уулзалт зохион байгуулсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.2 | Төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтод заасан албан тушаалын нэрийг нэг мөр хэрэглэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах | - | Зохион байгуулалтын арга хэмжээ авсан байдал | 0 | Цахим хурал зохион байгуулах, албан бичгээр чиглэл хүргүүлэх | - | Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль шинээр мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотой сумдын Засаг даргын тамгын газрын дарга нарт байгууллагын бүтэээ шинэчлэн батлах, батлахдаа мэргэжилтэн, албан хаагчдын батлагдсан албан тушаалын тодорхойлолтын нэр нэршлийг нэг мөр хэрэглэх талаар албан бичгээр зөвлөмж хүргүүлж, цахим уулзалт зохион байгуулсан. | 100 |
| **Зорилт 1.3** | **Олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандарт нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах** | 380.0 | Ажлын гүйцэтгэлийн хувь | 30 | Аймгийн ЗДТГ-т нэвтрүүлсэн байна | Сумдын ЗДТГ-т нэвтрүүлэх ажлыг удирдан зохион байгуулсан байна | Аймгийн Засаг даргын тамгын газрын үйл ажиллагаанд чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэх ажил 100 хувийн гүйцэтгэлтэй, 1<br>9 сумын Засаг даргын тамгын газраас 15 сум стандартын гэрчилгээ хүлээн авахад бэлэн болоод байна. | **100** |
| 1.3.1 | Аймгийн Засаг даргын тамгын газарт Олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандарт нэвтрүүлэх | 30.0 | Ажлын гүйцэтгэлийн хувь | 30 | 100 | - | Аймгийн Засаг даргын тамгын газрын үйл ажиллагаанд чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэх ажил 2021 оны 10 дугаар сараас эхлэн хийгдэж 2022 оны 05 сард зөвлөх үйлчилгээний ажлыг хүлээн авч, 06 дугаар сард хөндлөнгийн 2 шатны аудит хийлгэж, Олон улсын баталгаажуулалтын байгууллагаас гэрчилгээ хүлээн авсан. | 100 |
| 1.3.2 | Сумдын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагаанд Олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандарт нэвтрүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, дэмжлэг арга зүйгээр хангах | 350.0 | Баталгаажуулалт авсан сумын Засаг даргын тамгын газрын тоо | 0 | - | 19 | 19 сумын Засаг даргын тамгын газраас 4 сумын Засаг даргын тамгын газар нь “Менежмент ба ур чадварын хүрээлэн” ТББ-тай, 15 сумын Засаг даргын тамгын газар Зөвлөх үйлчилгээний компанитай гэрээ байгуулан ажиллаж байна. Аймгийн Засаг даргын тамгын газраас сумдад гэрээ байгуулах, зөвлөх үйлчилгээний явцад анхаарах асуудлаар зөвлөмж, чиглэл хүргүүлэн ажиллаж, 18 сум стандартын гэрчилгээ хүлээн аваад байна. | 100 |
| АХЖТ-ний зорилго 4.2. Чадахуйн зарчимд суурилсан, мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ. | | | | | | | | |
| **Зорилт 1.4** | **Төрийн захиргааны албан тушаалтнуудад** | - | Сургалтыг тухай бүр чанартай | - | Сургалтыг тухай бүр чанартай | Сургалтыг тухай бүр чанартай | Удирдлагын академи болон тус байгууллагаас зохион байгуулагдсан | **90** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **сургалт зохион байгуулж мэргэшүүлэх** | | зохион байгуулж, албан хаагчдыг жигд хамруулсан байх | | зохион байгуулж, албан хаагчдыг жигд хамруулсан байна | зохион байгуулж, албан хаагчдыг жигд хамруулсан байна | сургалтуудад сумдын ЗДТГ-н албан хаагчдыг тухай бүр хамруулсан. | |
| 1.4.1 | Төрийн захиргааны байгууллагуудын боловсон хүчний томилгоонд хяналт шалгалт хийж, зөвлөмж өгөх | - | - Ажилласан сум, байгууллагын тоо | 0 | 8 | 11 | 2022 онд 8 сумын Засаг даргын тамгын газар, төрийн байгууллагуудад ажиллаж боловсон хүчний томилгоонд хяналт шалгалт хийж, зөвлөмж өгч ажилласан | 70 |
| 1.4.2 | Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж, батлах | - | Хөтөлбөр боловсруулах ажлын хувь | 0 | 100 | Хэрэгжилтийг ханган ажиллана | Аймгийн ЗДТГ-н даргын 2022 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн А/10 дугаар тушаалаар батлагдсан. | 100 |
| 1.4.3 | Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр боловсруулж, батлах | | Хөтөлбөр боловсруулах ажлын хувь | 0 | 100 | Хэрэгжилтийг ханган ажиллана | Аймгийн ЗДТГ-н даргын 2022 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн А/9 дүгээр тушаалаар батлагдсан. | 100 |
| **Зорилт 1.5** | **Төрийн байгууллагуудын боловсон хүчний бодлогыг тасралтгүй хангаж ажиллах** | - | Боловсон хүчний бодлогыг хэрэгжүүлсэн байдал | Боловсон хүчний бодлогыг тасралтгүй хэрэгжүүлж ажилласан | Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт сайжирна | Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт сайжирна | Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавин, боловсон хүчний бодлогыг хэрэгжүүлж ажиллаж байна. | **100** |
| 1.5.1 | Төрийн албаны ерөнхий шалгалтыг зохион байгуулж, хүний нөөцийн сан бүрдүүлэх | - | Ерөнхий шалгалт зохион байгуулсан тоо | 4 | - | - | 2022 оны 04 дүгээр сарын 01, 02-ны өдрүүдэд Архангай аймагт зохион байгуулсан Төрийн албаны ерөнхий шалгалтад оролцохоор нийт 232 иргэн бүртгүүлснээс 201 иргэн шалгалтад оролцож, нийт шалгалтад оролцсон иргэдийн 35.8 хувь буюу 72 иргэн, 10-р сарын 14-ний зохион байгуулсан төрийн албаны ерөнхий шалгалтад оролцохоор нийт 157 иргэн бүртгүүлснээс 131 иргэн шалгалтад оролцож, нийт шалгалтад оролцсон иргэдийн 35.1 хувь буюу 46 иргэн, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | энэ онд нийт 118 иргэн төрийн жинхэнэ албанын нөөцөд бүртгэгдсэн. | |
| 1.5.2 | Төрийн захиргааны албан тушаалын сул орон тоог нөхөх | - | Тусгай шалгалт зохион байгуулж нөхсөн албан тушаалын тоо | 68 | - | - | 2022 оны 6 дугаар сард 5 тусгай шалгалт зохион байгуулж төрийн захиргааны удирдах 9, гүйцэтгэх 36, нийт 45 сул орон тоог журмын дагуу нөхсөн. 2022 оны 12 дугаар сард төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаал, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн албан тушаалын сонгон шалгаруулалтыг нийт 113 албан тушаалын 149 орон тоон дээр нээлттэй зарлаж, тусгай шалгалтуудыг журмын дагуу зохион байгуулж байна. | 100 |
| **Зорилт 1.6** | **Засаг даргын тамгын газрын дотоод ажил үүргийн уялдаа холбоог сайжруулж, төлөвлөгөөний гүйцэтгэл, үр дүнг хангах** | - | Төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг хугацаанд нь гаргасан байдал | Хугацаанд нь гүйцэтгэсэн | Байгууллагын болон нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хагас жилийн тайлан, үнэлгээ журмын хугацаанд хийгдсэн байна | Байгууллагын болон нэгжүүдийн гүйцэтгэлийн тайлан, үнэлгээ журмын хугацаанд хийгдсэн байна | Аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгжүүдээс санал авч нэгтгэн 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр төсвийн шууд захирагчаар батлуулан, төсвийн Ерөнхийлөн захирагчаар хянуулсан. Гүйцэтгэлийн тайланг хагас жилийн байдлаар 06 дугаар сарын 20-ны өдөр нэгтгэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. 2022 оны гүйцэтгэлийн тайланг хугацаанд нь нэгтгэж байна. | **100** |
| 1.6.1 | Засаг даргын тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг хугацаанд нь гаргах, цаг үеийн шинжтэй үйл ажиллагааг зохион байгуулалт, арга зүйгээр хангах | - | -Төлөвлөгөөг хугацаанд нь боловсруулж батлуулсан байдал<br>-Тайланг хугацаанд нь гаргаж дүгнэсэн байдал | Хугацаанд нь гүйцэтгэсэн | 01/05-ны өдрийн дотор төлөвлөгөөг баталсан байна, хагас жилийн тайлан гаргасан байна | 12/20-ны дотор жилийн эцсийн тайланг гаргаж, ХШҮ хийсэн байна | Аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгжүүдээс санал авч нэгтгэн 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр төсвийн шууд захирагчаар батлуулан, төсвийн Ерөнхийлөн захирагчаар хянуулсан. Гүйцэтгэлийн тайланг хагас жилийн байдлаар 06 дугаар сарын 20-ны өдөр нэгтгэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. 2022 оны гүйцэтгэлийн тайланг хугацаанд нь нэгтгэж байна. | 100 |
| 1.6.2 | Нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг хугацаанд нь гаргах, цаг | - | -Төлөвлөгөөг хугацаанд нь боловсруулж | Хугацаанд нь гүйцэтгэсэн | 01/07-ны өдрийн дотор төлөвлөгө | 12/20-ны дотор жилийн эцсийн | Хэлтсүүдийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр Засаг даргын тамгын газрын даргаар батлуулан хэрэгжүүлж байна. Бүх | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үеийн шинжтэй үйл ажиллагааг зохион байгуулалт, арга зүйгээр хангах | | батлуулсан байдал<br>-Төлөвлөгөөний биелэлтийг хугацаанд нь гаргаж дүгнэсэн байдал | | өг баталсан байна, хагас жилийн тайлан гаргасан байна | тайланг гаргаж, ХШҮ хийсэн байна | хэлтэс 2022 оны хагас жилийн гүйцэтэтгэлийн тайланг 06 дугаар сарын 17-ны өдөр гаргаж Төсвийн шууд захирагчаар хянуулан ажилласан бөгөөд 2022 оны тайланг гаргаж төсвийн шууд захирагчаар хянуулан ажиллаж байна. | |
| **Зорилт 1.7** | **Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах** | - | Шийдвэрлэлтийн хувь | 96.3 | 97 | 97 | Иргэдээс тус байгууллагад хандаж гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч, удирдлагад танилцуулан, цохолтын дагуу тухайн албан тушаалтанд шилжүүлж, хуулийн хугацаанд шийдвэрлүүлж байна. | **90** |
| 1.7.1 | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, агентлаг сумдын өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг нэгтгэх, тайлагнах үйл ажиллагаанд хяналт тавих, арга зүйн удирдлагаар хангах | - | -Журмын дагуу тайлагнасан байдал<br>-Зөвлөн туслах ажил гүйцэтгэсэн байдал | -Журмын дагуу тайлагнаж, Зөвлөмж хүргүүлэн ажиллад аг | -Журмын дагуу тайлагнасан байна<br>-Зөвлөн туслах ажил гүйцэтгэсэн байна | -Журмын дагуу тайлагнасан байна<br>-Зөвлөн туслах ажил гүйцэтгэсэн байна | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, агентлаг сумдын өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг улирал тутам нэгтгэж, дүнг аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн, дүнг ЗГХЭГ-т хүргүүлж байна. | 90 |
| **Зорилт 1.8** | **Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж сайн түншлэлийг бий болгох** | - | Харилцаа, хамтын ажиллагаа өргөжсөн эсэх | 0 | Харилцаа, хамтын ажиллагаа өргөжүүлнэ | Харилцаа, хамтын ажиллагаа өргөжүүлнэ | 2022 онд нийт 7 улсын гадаадын зочид төлөөлөгч нартай албаны уулзалт хийж, Бүгд найрамдах Турк улсад албан айлчлал хийсэн байна. | **77,5** |
| 1.8.1 | Найрамдалт хамтын ажиллагаатай улс орнуудтай хамтын ажиллагааг идэвхижүүлж, хамтран ажиллах | - | -Элчин сайдын яамд болон улс орнуудтай хамтран ажилласан тоо | 0 | 3-5 | 10 | 2022 онд нийт 7 улсын гадаадын зочид төлөөлөгч нартай албаны уулзалт хийж, Бүгд найрамдах Турк улсад албан айлчлал хийсэн байна. | 70 |
| 1.8.2 | Төрийн албан хаагчид, шаардлагатай салбарын мэргэжилтнүүдийг гадаад арга хэмжээнд оролцуулах, туршлага судлуулах, богино хугацаагаар мэргэжил | - | - Гадаадад сургалт, арга хэмжээнд хамрагдсан албан хаагчдын тоо | 0 | 2 | 3 | 2022 онд аймгийн Засаг дарга болон Засаг даргын орлогч, зөвлөх нар Бүгд найрамдах Турк улсад айлчлал хийж хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан. | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дээшлүүлэх сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулах | | | | | | | |
| 1.8.3 | Олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг эрчимжүүлэх, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх | - | Хамтын ажиллагаатай олон улсын байгууллагын тоо | 2 | 2 | 3 | Олон улсын төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт Хүн амын сан Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл 2-р шатны хэрэгжилт 100%, Тариат сумын Суман багт хэрэгжиж байгаа Тогтвортой хөгжлийн боловсрол 2 төслийн гүйцэтгэл 100%, Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл Эрдэнэмандал, Хайрхан, Төвшрүүлэх сумдад амжтлттай хэрэгжиж байна. | 90 |
| 1.8.4 | Дипломат болон албан гадаад паспортыг шаардлагатай болон авах эрх бүхий албан хаагчдад олгуулах | - | Эрх бүхий албан хаагчдын дипломат, албан гадаад паспортын мэдүүлгийг дээд шатны байгууллагад мэдүүлсэн тоо | 3 | 2 | 3 | Албаны гадаад пасспорт 2022 онд 3 удаа мэдүүлсэн байна. | 100 |
| **Зорилт 1.9** | **Төрийн дээд цол, одон медаль, аймгийн шагналаар шагнуулах иргэдийн шагналыг шуурхай шийдвэрлэх** | - | Төрийн дээд цол, одон медаль, аймгийн шагналаар шагнуулах иргэдийн шагналыг шуурхай шийдвэрлэсэн байдал | Тухай бүр шуурхай шийдвэрлэсэн | Ойролцоогоор 100 иргэний материалыг шийдвэрлүүлсэн байна | Ойролцоогоор 200 иргэний материалыг шийдвэрлүүлсэн байна | Сум болон байгууллагаас ирсэн шагналын материалуудыг цаг тухай бүрт нь шийдвэрлэн ажилласан. | **100** |
| 1.9.1 | Монгол Улсын Төрийн дээд цол, одон медалиар шагнуулах иргэдийн иргүүлсэн материалыг хянаж бүрдэл хангасан тодорхойлолтыг системийн дээд байгууллагад илгээж санал аван шийдвэрлэх | - | Шаардлага хангасан шагналын материалыг хянуулсан тоо | - | 100 | 200 | 2022 оны байдлаар 453 иргэний шагналын материалыг программд шивж Ерөнхийлөгчийн тамгын газарт хүргүүлсэн байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.9.2 | Аймгийн Засаг даргын шагналд тодорхойлогдсон иргэд, байгууллагын тодорхойлолтыг тухай бүр судлан шийдвэрлүүлэх асуудлыг зохион байгуулах | - | Журамд заасан шалгуурыг хангасан байгууллага, иргэн, албан хаагчдыг шагнасан байдал | - | Тухай бүр шуурхай шийдвэрлэж журмын хүрээнд ажиллана | Тухай бүр шуурхай шийдвэрлэж журмын хүрээнд ажиллана | Аймгийн Засаг даргын хүндэт тэмдэгээр 306 иргэн, аймгийн Тэргүүний ажилтан тэмдэгээр 215 хүн, Жуух бичигээр 421 иргэн, хүндэт өргөмжлөлөөр 142 иргэнийг тус тус шагнасан байна. | 100 |
| МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ | | | | | | | | |
| **Зорилт 1.10** | **Мэдээллийн технологийн ашиглалт, аюулгүй байдал, хэвийн ажиллагааг хангаж ажиллах** | - | Аймгийн Засаг даргын тамгын газрын комьютер тоног төхөөрөмж, сүлжээний хэвийн ажиллагаа хангагдсан эсэх /1-тийм, 0-үгүй/ | 0 | 1 | 1 | Алба хаагчдад мэдээлийн технологийн зөвлөгөөг тухай бүр өгч ажиллаж байна<br>Албан хаагчдын техник тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж удирдлагад танилцуулсан. | **95** |
| 1.10.1 | Байгууллагын албан хаагчдын техник хэрэгсэлийн бүрэн бүтэн байдал, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах | - | -Техник хэрэгсэл, сүлжээний хэвийн жигд ажиллагааг хангасан байдал | Техник хэрэгсэл, сүлжээний хэвийн жигд ажиллагааг хангаж ажиллана | Техник хэрэгсэл, сүлжээний хэвийн жигд ажиллагааг хангаж ажиллана | Техник хэрэгсэл, сүлжээний хэвийн жигд ажиллагааг хангаж ажиллана | Засаг даргын тамгын газрын алба хаагчдын компьютер техник хэрэгслийн гэмтэлийг тухай бүр засварлаж хэвийн ажиллах боломжоор хангасан 2022 оны 06 сарын 10 нд сүлжээний төхөөрөмж шатсан гэмтэлийг шийдвэрлэж ажилласан. | 90 |
| 1.10.2 | Сүлжээ болон вэб сайтын хэвийн ажиллагааг хангах | - | Вэб сайтад оруулсан мэдээний тоо | 0 | 120 | 240 | Arkhangai.gov.mn вэб сайтад 2022 оны 6 сарын байдлаар 115022 иргэн хандалт хийж 168 мэдээлэл шинээр оруулсан. | 100 |
| **Зорилт 1.11** | **Олон нийтийг чанартай, бодитой мэдээллээр шуурхай хангаж, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх** | - | Телевизийн пэйж хуудсын хандалт, сонин захиалагчдын тоо, arkhangai.gov.mn сайтад хандсан иргэний тоо | -15.000<br>-<br>- | Телевизийн пэйж хуудсын хандалт, сонин захиалагчдын тоо, arkhangai.gov.mn сайтад хандсан | Телевизийн пэйж хуудсын хандалт, сонин захиалагчдын тоо, arkhangai.gov.mn сайтад хандсан | 28 хоногт дунджаар 750 мянган иргэнд, Архангай амьдрал-2000 захиалагч, Архангайн толь 1000 захиалагч мэдээллийг өөрсдийн сувгуудаар авч байна. | **70** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | иргэний тоог нэмэгдүүлсэн байна | иргэний тоог нэмэгдүүлсэн байна | | |
| 1.11.1 | Аймгийн Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж олон нийтэд сурталчлах, мэдээлэх, архивлах, arkhangai.gov.mn сайтын мэдээллийг байнга шинэчилж, идэвхжүүлэх | - | -Телевизийн мэдээний тоо<br>-Сонины мэдээний тоо<br>-Цахим мэдээний тоо | 100<br>120<br>500 | 50<br>60<br>250 | 100<br>120<br>500 | Орон нутгийн АВ телевизээр 2022 онд аймгийн ЗДТГ-ын нийт 72 төрлийн 144 минутын мэдээ, Архангайн амьдрал, Архангайн толь сонинд 32 нүүр бүхий 65 ширхэг цаг үеийн мэдээ, аймгийн ЗДТГ-ын албан ёсны цахим сайтад 1083 ширхэг мэдээнүүд тус тус нийтлэгдэж, цацагджээ. | 70 |
| 1.11.2 | Төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах | - | Гэрээ байгуулсан телевиз, сонин, сайтын тоо | -3<br>-2<br>-2 | Телевиз-2, Сонин-3, сайт-2 | Байгуулсан гэрээний дагуу хяналт тавьж ажиллана | 2022 онд аймгийн Засаг дарга орон нутгийн АВ телевиз, Архангайн амьдрал сонин, Архангайн толь сонинтой гэрээ байгуулан хяналт тавьж ажиллалаа. | 70 |
| АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ | | | | | | | | |
| **Зорилт 1.12** | **Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хууль тогтоомж, стандартад нийцүүлэн хэрэгжилтийг сайжруулах** | - | Журмын дагуу ажилласан байдал | Журмын дагуу ажилласан | Журмын дагуу ажилласан байна | Журмын дагуу ажилласан байна | Архив, албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу ирсэн 3738 албан бичиг, явуулсан 2082 албан бичиг бүртгэл хөтлөж удирдлагад танилцуулан, удирдлагын заалтын дагуу хэлтэс нэгжид шилжүүлж, 171 албан бичигт бүртгэл хяналтын карт хөтлөн шийдвэрлэлтэд хяналт тавьж байна. | **96** |
| 1.12.1 | Архивын зориулалтын өрөө тасалгаа, тоног төхөөрөмжөөр хангах | - | -Зориулалтын өрөөгөөр хангагдсан байх<br>-Стандартад нийцсэн шүүгээтэй болсон байх | -Зориулалтын өрөө байхгүй<br>-Нягтруулсан шүүгээгүй | - | -Зориулалтын өрөөтэй болж, нягтруулсан шүүгээтэй болно | Архивын тасагт 2022 оны 5 дугаар сард 2425 маркийн канон, сканер, цахимжуулалтын серверийн 1400VA хүчин чадалтай “APC” брендийн тог баригчийг шинээр авч өгч техник тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийж, албан хаагчдын хэвийн ажиллах нөхцөл бололцоог хангаж, 70 $м^2$ бүхий үйлчилгээний заал, ажилчдын өрөөг засварлан тохижуулж, ажиллах нөхцөлийг сайжруулсан. | 100 |
| 1.12.2 | Захирамжлалын баримт бичгийг 2020 он хүртэл цахимд шилжүүлэх | - | Цахимд шилжүүлсэн хувь | 50 | 75 | 100 | Захирамжлалын баримт бичиг нийт 8 хадгаламжийн нэгж буюу 1475 хуудсыг нэг бүрчлэн нягтлан шалгаж сканнердаж, сканнердсан баримт бичгийг photoshop | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | программаар PDF файл болгон ашиглалтын болон мастер хувь үйлдэн цахим санд хадгалсан. Нийт сканнердаж цахим үүсгэсэн 9 хадгаламжийн нэгж буюу 1584 хуудас баримтад тодорхойлолт бичилт хийсэн. Сканнердаж, баримт бичгийн баримтын түвшинд тодорхойлон бичилт хийсэн 30 хадгаламжийн нэгж буюу 5897 хуудас баримтыг архивын программд холбож цахим мэдээллийн санг үүсгэсэн. | |
| 1.12.3 | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг сайжруулах | - | -Сургалт зохион байгуулсан сургалтын тоо<br>-Холбогдох журмыг шинэчлэн боловсруулна | 0<br>0 | 1<br>1 | 1 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, шинэчилсэн журам зэргийг байгууллагын хэмжээнд нийцүүлэн боловсруулж, байгууллагын даргаар батлуулан, нийт албан хаагчид танилцуулан сургалт зохион байгуулж журмыг дагаж мөрдүүлэн ажиллаж байна. | 100 |
| **Зорилт 1.13** | **Архивын ажил үйлчилгээг боловсронгуй болгох, иргэд олон нийтэд сурталчлан таниулах** | Улс, орон нутгийн төсөв | Архивын үйл ажиллагааг сайжруулж, иргэд олон нийтэд сурталчилан таниулсан байх | - | | Архивын үйл ажиллагаа сайжирсан байна | “Хуульчийн про боно өдөр–2022” өдөрлөг, байгууллагуудын нээлттэй хаалганы өдрийг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр аймгийн нутгийн захиргааны ордны төв талбайд зохион байгуулж, Албан хэрэг хөтлөлтийн тухай зөвлөгөө мэдээллийг өгч, гарын авлага, брошурыг тараан, хууль эрх зүйн мэдлэг, боловср олыг нэмэгдүүлэн ажиллалаа. | **60** |
| 1.13.1 | Архивын лавлагаа үйлчилгээ, цахим сан бүрдүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж техник, тоног төхөөрөмжөөр хангах | Улс, орон нутгийн төсөв | Үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн техник, тоног төхөөрөмжийн тоо | - | - | Архивын үйл ажиллагаанд шаардлагатай техник, тоног төхөөрөмжүүдийг шинэчилсэн байна | Архивын тасагт 2022 оны 5 дугаар сард 2425 маркийн канон, сканер, цахимжуулалтын серверийн 1400VA хүчин чадалтай “APC” брендийн тог баригчийг шинээр авч өгч техник тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийж, албан хаагчдын хэвийн ажиллах нөхцөл бололцоог хангаж, 70 $м^2$ бүхий үйлчилгээний заал, ажилчдын өрөөг засварлан тохижуулж, ажиллах нөхцөлийг сайжруулан ажилласан. | 100 |
| 1.13.2 | Архивын хадгаламжийн сангийн агааржуулалтын системийг шинэчлэх | Орон нутгийн төсөв | Засвар, үйлчилгээ хийгдсэн тоо | 0 | - | Хадгаламжийн сангийн агааржуулалтын | Төрийн хэмнэлтийн хууль гарсантай холбоотой энэ ажил хэрэгжээгүй | 0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | системийг шинэчлэн засварлас ан байна | | |
| 1.13.3 | Төрийн архивын ажилтнууд болон төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудыг мэргэжлийн байгууллагын сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах | Орон нутгийн төсөв | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | 11 | - | 15 | Хөдөлмөрийн тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон хүний эрхийн ойлголт, хувь хүний хөгжил, нийтийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зэрэг нийт 10 төрлийн сэдвээр 19 сумын эрх зүйч, архив бичиг хэргийн эрхлэгч нарт 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдөр танхимаар 7 цагийн сургалт, мэдээллийг зохион байгуулсан. Сургалтад нийт 19 сумын 35 алба хаагч оролцож, хууль эрх зүйн мэдлэг, чадвараа нэмэгдүүлсэн.<br>Архивын ерөнхий газрын анхан шатны сургалтад 5, мэргэшүүлэх сургалтад 7 хөмрөг үүсгэгч байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтныг хамруулсан байна.<br>Мөн 2022 оны 03 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд Архивын Ерөнхий газраас зохион байгуулсан мэдээллийн технологийн сургалтад Архивын тасгийн сан хөмрөгч Ш.Зулбаяр, цахимжуулалтын гэрээт ажилтан Х.Насанбат нар хамрагдсан. | 100 |
| 1.13.4 | Хөмрөг үүсгэгч байгууллага аж ахуйн нэгжүүдэд архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтыг 2-оос доошгүй удаа зохион байгуулах | Улсын төсөв | Зохион байгуулсан сургалтын тоо | - | - | 2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна | Энэ оны 04 дүгээр сарын 11-ний өдөр хөмрөг үүсгэгч байгууллага болох Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Монгол банкны Архангай аймаг дахь салбар зэрэг байгууллагуудад архивын үзлэг явуулж, архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, болон “Төрийн албан хэрэг хөтлөлтийн журам”-ын сургалт зохион байгуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.<br>2022.12.16-ны өдөр сумдын ЗДТГ-ын архив, бичиг хэргийн эрхлэгч, төсөвт байгууллагуудын архив, бичиг хэргийн ажилтан, ЗД-н эрхлэх хүрээний 28 агентлаг, аймгийн төвийн сургууль, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | цэцэрлэгийн архив, бичиг хэргийн ажилтан нийт 115 албан хаагчид архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, хуулийг дагалдан шинэчлэгдсэн журам, стандартаар 1 өдрийн сургалт, арга хэмжээ зохион байгуулсан. | |
| 1.13.5 | Архивын тасгаас 19 сумын төрийн байгууллагуудад төлөвлөгөөт архивын үзлэгийг зохион байгуулна | Орон нутгийн төсөв | Архивын үзлэгийг зохион байгуулсан тоо | - | - | 19 сумын төрийн байгууллагуудад архивын үзлэгийг зохион байгуулсан байна | Архивын тасгийн дарга, Архив албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагч жирэмсний амралттай байсан тул энэ ажил хийгдээгүй. | 0 |
| НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТ | | | | | | | | |
| **Зорилт 1.14** | **Өсвөрийн болон паралимпын шигшээ багийг шинэчлэн байгуулах** | - | Шигшээ баг байгуулсан шийдвэр | Шигшээ баггүй | - Өсвөрийн шигшээ багийг 8-12, паралимпийн шигшээ багийг 1 төрлөөр байгуулсан шийдвэрийг гаргуулсан байна | - | Шигшээ баг байгуулах болон шигшээ багийн ажиллах журмын төсөл бэлэн болсон. Шигшээ багийг ажиллуулах санхүүжилтийг ямар эх үүсвэрээс гаргах асуудал тодорхойгүй шалтгаанаар захирамж гараагүй хүлээгдэж байна. | **30** |
| 1.14.1 | Өсвөрийн шигшээ багийг шинэчлэн байгуулах | - | Байгуулах төрлийн тоо | Шигшээ баггүй | Захирамж гаргуулсан байна | - | Холбогдох хууль, тогтоомжийн дагуу аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийг чөлөөт бөх, жүдо бөх, волейбол, хөнгөн атлетик, бадминтон, шатар, даамын төрлүүдээр байгуулахаар ажиллах журмын төслийг боловсруулан бэлэн болгосон. Тус шигшээ багийг байгуулж ажиллуулахад нэг жилд 450 гаруй сая төгрөг шаардагдах төсвийн тооцоо судалгааг гаргасан. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгэм, цахим бодлогын хөгжлийн хорооны хурлаар энэхүү асуудлыг хэлэлцүүлсэн. | 30 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.14.2 | Өсвөрийн болон паралимпын шигшээ багийг шинэчлэн байгуулах | - | Байгуулах төрлийн тоо | Шигшээ баггүй | | - | Парахөнгөн атлетикийн төрлөөр тамирчид хичээллэж байна. Энэ төрлөөр шигшээ баг байгуулахаар төлөвлөсөн. Биеийн тамир спортын газраас паралимпийн тамирчдын бэлтгэл сургуулилт хийх орчин бүрдүүлэн ажиллаж байна. | 30 |
| ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ТАЛААР | | | | | | | | |
| АХЖТ-ний 4.3**.** Гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулахад төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, батлан хамгаалах хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангана. | | | | | | | | |
| **Зорилт 2.1** | **Хууль, эрх талаар мэдлэг олгох сургалт, сурталчилгааг зохион байгуулах** | Тухай бүр | Сургалтад хамрагдсан хүний тоо | 2021 оны сургалтад хамрагдсан хүний тоо | 200 | 300 | Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар, ГБХЗХГ, Хүний эрхийн үндэсний комисс, Татварын хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтран Хөдөлмөрийн тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилсан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон хүний эрхийн ойлголт, хувь хүний хөгжил, нийтийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Хүний эрх, Нөхөн үржихүйн эрх зэрэг нийт 15 төрлийн сэдвээр аймгийн сум, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, аж ахуй нэгж байгууллагын нийт 850 гаруй албан хаагчийг хамруулан танхим болон цахимаар сургалт зохион байгууллаа. 18 төрлийн постер, шторк бэлдэж цахим мэдээллийн системээр давхардсан тоогоор 16500 гаруй хүнд хүргэх ажлыг зохион байгуулсан.<br>Улсын хэмжээнд зохион байгуулагдсан "Хуульчийн про боно өдөр–2022" өдөрлөг, байгууллагуудын " Нээлттэй хаалганы өдөр"-ийг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр аймгийн нутгийн захиргааны ордны төв талбайд зохион байгуулж, нийт төрийн 31 байгууллага оролцож иргэдэд хууль эрх зүйн зөвлөгөөг үнэ төлбөргүй өгч, 8 төрлийн 263, нийт 2100 ширхэг гарын | **100** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | авлага, брошурыг тараан, хууль эрх зүйн мэдлэг, боловсролыг нэмэгдүүллээ. | |
| 2.1.1 | Сургалт, сурталчилгааны төлөвлөгөө боловсруулан үе шаттайгаар хэрэгжүүлэх | Тухай бүр | -Зохион байгуулсан сургалтын тоо<br>-Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | - | 200 | 300 | Сургалт, сурталчилгааны 2022 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, 13 удаагийн сургалтыг 16500 гаруй төрийн албан хаагч, багш, сурагчид, иргэд олон нийтийг хамруулан зохион байгуулан ажиллаа. | 100 |
| **Зорилт 2.2** | **Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, хууль хяналтын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах** | Тухай бүр | Гэмт хэрэг зөрчлийн бууралтын хувь | 23.4 | - | 23.3 | Хууль хяналтын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр хууль хүчний байгууллагуудын нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж, иргэд олон нийтэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа.<br>Аймгийн хэмжээнд 306 холбогдогчтой эрүүгийн 358 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулбал гэмт хэрэг 79 хэргээр буюу 18, холбогдогч 26 буюу 7.8, иргэдийн өмчийн хулгайн гэмт хэрэг 37 буюу 39.1, мал хулгайлах гэмт хэрэг 44 буюу 44.4, залилан мэхэлж авах гэмт хэрэг 5 буюу 19.2 хувиар тус тус буурсан байна. | **95** |
| 2.2.1 | Тодорхой төрлийн өсөлттэй байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцөлийн судалж, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг зохион байгуулах | Тухай бүр | Гэмт хэрэг зөрчлийн бууралтын хувь | 2021 оны жилийн эцсийн дүн | Өмнөх оноос буурсан байна | Өмнөх оноос буурсан байна | Малын хулгайн гэмт хэрэг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 46.34 хувиар өссөн дүнтэй байх бөгөөд Малын хулгайн гэмт хэргийг илрүүлэх, тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор энэ оны эхний хагас жилд сумдын болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран 3 суманд 700 гаруй малчид төр захиргааны албан тушаалтныг оролцуулсан “Малчдын зөвлөгөөн”-ийг зохион байгуулсан. Зөвлөгөөнд оролцогчдод “Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд малчдын үүрэг хариуцлага”, “Аймаг орон нутгийн гэмт хэрэг, зөрчлийн сар бүрийн нөхцөл байдал, анхаарах асуудал зэрэг | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сэдвээр сургалт мэдээлэл зохион байгуулан ажилласан байна. | |
| 2.2.2 | Аймгийн төвийн гудамж талбайд камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх | Тухай бүр | Камержуулалтын тоо | - | | Тодорхой цэгүүдийг камержуулах | Аймгийн төвд орон нутгийн санхүүжилтээр 2017 онд 7.9 сая төгрөгөөр 5, 2018 онд 44.9 сая төгрөгөөр 22, 2019 онд 26.8 сая төгрөгөөр 8, 2020 онд 55 сая төгрөгөөр “Утасгүй сүлжээний бааз станц” 2 цэгт 2 ширхэг, хяналтын камер 2 цэгт 3, зориулалтын “Video wall” ханын дэлгэцийн төхөөрөмж, 32 сувгийн 3 ширхэг бичлэг хадгалах төхөөрөмж /NVR/, 2022 онд 450 сая төгрөгөөр 21 цэгт чиглэлийн 60, эргэдэг 5, нийт 65 ширхэг камерыг шинээр суурилуулан энэ оны 09 дүгээр сард ашиглалтад оруулсан. Мөн энэ онд хийгдсэн камержуулалтын ажлын явцад өмнө нь ашиглаж байсан 18 хяналтын цэгт 39 ширхэг камер, түүний дэд бүтцэд засвар үйлчилгээг ажлын гүйцэтгэгч “Оргилуун үйлс" ХХК-аар хийлгүүлснээр өнөөдрийн байдлаар аймгийн төвийн хэмжээнд 104 ширхэг камерыг "Теле хяналтын камерын Төв"-д холбосон | 100 |
| **Зорилт 2.3** | **Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эсрэг чиглэсэн гэмт хэрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд онцгой анхаарна** | Тухай бүр | Сургалт, тэмцээн нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан байна. | 30 | Гэмт хэргийн гаралт буурсан байна | Гэмт хэргийн гаралт буурсан байна | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг олон нийтэд мэдээлэх сурталчлан таниулах ажлын хүрээнд 8 төрлийн постер бэлдэж давхардсан тоогоор 1000 гаруй хүнд хүргэх ажлыг зохион байгуулсан. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт нөлөөллийн арга хэмээг Гэр бүл, хүүхэд, залуучуудын газартай хамтран 1400 гэр бүлийг хамруулан зохион байгуулсан. | **90** |
| 2.3.1 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулгах | Тухай бүр | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 1 | 1 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэх тэдний өмнө тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, хүртээмжтэй орчин бий болгох, сургалт нөлөөллийн ажил, хувийн туслах үйлчилгээний төсөвт аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 10.0 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааны | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зардалд 3.0 сая төгрөг нийт 13.0 сая төгрөгийг шийдвэрлүүлэн ажилласан байна. | |
| 2.3.2 | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ. | Тухай бүр | Сургалт, тэмцээн нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан байна. | - | - | Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг буурна | Аймгийн ГХУСАЗСЗ, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Хүний Эрхийн Үндэсний комисс, Засаг даргын тамгын газрын Хуулийн хэлтэстэй хамтран Хотонт, Төвшрүүлэх, Булган, Цэнхэр, Их тамир сумдын 540 иргэн сургалтад хамрагдаж 15 төрлийн 786 ширхэг постер, гарын авлага, зурагт хуудас тарааж ажиллаа.<br>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг олон нийтэд мэдээллэх сурталчлан таниулах ажлын хүрээнд 8 төрлийн постер бэлдэж давхардсан тоогоор 16500 гаруй хүнд хүргэх ажлыг зохион байгуулсан. Мөн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар, ГБХЗХГ, Хүний эрхий үндэсний комисс хамтран “Хүчирхийлэлгүй гэр бүлийг хамтдаа бүтээцгээе” аяныг өрнүүлж, Төвшрүүлэх, Хотонт, Булган, Цэнхэр, Ихтамир зэрэг сумдын 500 гаруй хүнд сургалт сурталчилгааг зохион байгуулсан.<br>Хууль, эрх зүйн хэлтэс, Хүний эрхийн үндэсний комиссын Архангай аймаг дахь референттэй хамтран аймгийн Цагдаагийн газрын эмэгтэй албан хаагч, Нэгдсэн эмнэлэгийн эмч, ажилтанд “Хүний эрх”, “Нөхөн үржихүйн эрх” зэрэг сэдвээр 2 өдөр 50 албан хаагчдад сургалт зохион байгуулсан. | 100 |
| 2.3.3 | Хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд оролцохоос урьдчилан сэргийлэх аажлыг зохион байгуулах | Тухай бүр | Сургалт, тэмцээн нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан байна. | 11 | Хүүхэд оролцсон гэмт хэрэг буурна | Хүүхэд оролцсон гэмт хэрэг буурна | Аймаг орон нутгийн хэмжээнд насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хүүхэд хамгаалал”, “Стандарт-2022”, “Тамхи”, “Камер-2022”,“Сэрэмжлүүлье” зэрэг арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцсон.<br>Арга хэмжээний хүрээнд ерөнхий боловсролын 25 сургуулийн захирал, 38 цэцэрлэгийн удирдлагуудыг оролцуулсан фэйсбүүк групп нээж хүүхдийг гэмт хэрэг, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зөрчилд өртөж, хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр нэгдсэн мэдээллээр тухай бүр хангаж, 38 цэцэрлэгийн ахлах бүлэг, ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагч нарт түгээх чиглэлээр 4 заалт бүхий зөвлөмж хүргүүлэн биелэлтийг тооцсон.<br>Мөн "School police" эцэг эхийн эргүүл ажиллуулах журмыг хэрэгжүүлж эхэлсэнээр аймгийн ерөнхий боловсролын 5 сургуулийн 80 гаруй анги бүлгийн 5000 гаруй эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч 2-4 ээлжээр сургуулийн орчинд эргүүлийн үүрэг гүйцэтгэж, сурагчдыг замын хөдөлгөөнд зөв боловсон оролцуулах, зөв дадал хэвшил олгох ажлыг 2021-2022 оны хичээлийн жилийн 9-12 сарын хугацаанд хэрэгжүүлэн ажилласнаар сургуулийн орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил бүртгэгдээгүй байна | |
| **Зорилт 2.4** | **Авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион зохион байгуулна** | Тухай бүр | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж үйл ажиллагаа зохион байгуулсан байна. | - | Авлигын эсрэг үйл ажиллагааны хэрэгжилтийг хангаж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Авлигын эсрэг үйл ажиллагааны хэрэгжилтийг хангаж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн сургагч багш нартай хамтран "Авлигын тухай ойлголт,илрэх хэлбэр, хор хөнөөл", "Авлигын хор уршиг, ард түмэнд үйлчлэх зарчим ба ашиг сонирхлын зөрчил" сэдвээр төрийн болон төрийн бус байгууллага, Ерөнхий боловсролын 11 сургууль, 15 цэцэрлэгийн нийт удирдлага, багш, ажилчид, албан хаагчдийг хамруулан "Авлигын тухай ойлголт,илрэх хэлбэр, хор хөнөөл", "Авлигын хор уршиг, ард түмэнд үйлчлэх зарчим ба ашиг сонирхлын зөрчил" сэдвээр сургалтыг танхимаар 14 хоногийн хугацаатай зохион байгууллаа. | **100** |
| 2.4.1 | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллах | Тухай бүр | Сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан байна. | Сургалт, сурталчилгааг 36000 гаруй иргэнд хүргэсэн. | Төлөвлөгөө боловсруулж батлуулсан байна. | Хэрэгжилтийг нь хангаж ажилласан байна. | Аймгийн Авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөөг 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдөр боловсруулж, аймгийн Засаг даргын тамгын газрын даргаар батлуулж, Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн сургагч багш нартай хамтран 4 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | удаагийн тамхимын сургалтыг төрийн албан хаагчид, Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчид, сурагчид болон МСҮТ-ийн багш, оюутануудад “Авлигын тухай ойлголт, илрэх хэлбэр, хор хөнөөл”, “Авлигын хор уршиг, ард түмэнд үйлчлэх зарчим ба ашиг сонирхлын зөрчил” сэдвээр сургалт зохион байгууллаа. | |
| **Зорилт 2.5** | **Цагдаагийн газрын барилгын ажлыг эхлүүлэх** | 1.290.0 | Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь | - | Барилгын ажлын гүйцэтгэлийг 10 хувьд хүргэнэ | Барилгын ажлын гүйцэтгэлийг 25 хувьд хүргэнэ | Тус цагдаагийн газрын шинээр баригдах барилгыг Улсын төсвийн 2022-2023 оны хөрөнгө оруулалтаар 5.4 тэрбум төгрөгийн өртөггэйгөөр барихаар тусгагдаж, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 10- ны өдрийн А/284 дүгээр тушаалаар орон нутагт гүйцэтгэгч компанийг сонгон шалгаруулах эрхийг шилжүүлэн тендер шалгаруулах ажлыг зохион байгуулж 2022 оны 04 дүгээр сарын 01-нд гүйцэтгэгчээр “Гранд арслан” ХХК шалгарсан байна. Барилгын ажил 30 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна | **100** |
| ГУРАВ. ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ТАЛААР | | | | | | | | |
| ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ | | | | | | | | |
| АХЖТ-ний зорилго 3.2. Хөдөө аж ахуйн салбарт шинэ техник, технологи нэвтрүүлж, түүхий эдийн нөөц ашиглалтыг сайжруулан, бичил, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэн, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлж, хүн амыг чанартай баталгаат аюулгүй хүнсээр тогтвортой хангана. | | | | | | | | |
| **Зорилт 3.1** | **Мал аж ахуйг байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалах, малчин өрхүүд өвс, тэжээл тарих, нөөц бүрдүүлэхэд нөхцөлийг бүрдүүлнэ.** | 400.0 | Тэжээлийн ургамал тариалсан га талбай | 200 га | - | 735 га | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Малын ногоон тэжээл” тариалах төслийн хүрээнд аймгийн Техник үйлчилгээний төвд тус бүр 2 ширхэг анжис, борнойг нийлүүлээд байна. Аймгийн 18 сумын 930 өрхийн 430 га өвөлжөө, хаваржааны газарт малын тэжээлийн ургамал тариалах захиалгыг нэгтгэн аймгийн Техник дундын үйлчилгээний төвд хүргүүлсэн. Мөн Хөдөө аж ахуйг дэмжих санд үрийн захиалгыг өгч үрийг татан авсан. Үүний үр дүнд 17 сумын 88 багийн 880 өрх 430 га талбайд 74.8 тн хошуу будааны үрийн дэмжлэг үзүүлсэн ба Жаргалант, Эрдэнэмандал, Төвшрүүлэх, Цэцэрлэг сумдын малчид өвөлжөө, хаваржааныхаа хөл бууцанд, бусад 13 | **90** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сумд нэгдсэн талбайд техникийн төвөөр тариалалт хийлгэж, 600 гаруй тн ногоон тэжээлийг хураан авсан. | |
| 3.1.1 | Малчдын өвөлжөө, хаваржаанд тэжээлийн ургамал тариалахад дэмжлэг үзүүлэх | 400.0 | Дэмжлэг үзүүлсэн малчин өрхийн тоо | 11 сумын 40 өрх | 500 | 19 сумын 1010 өрх | 17 сумын 88 багийн 880 өрх 430 га талбайд 74.8 тн хошуу будааны үрийн дэмжлэг үзүүлсэн ба Жаргалант, Эрдэнэмандал, Төвшрүүлэх, Цэцэрлэг сумдын малчид өвөлжөө, хаваржааныхаа хөл бууцанд, бусад 13 сумд нэгдсэн талбайд техникийн төвөөр тариалалт хийлгэж, 600 гаруй тн ногоон тэжээлийг хураан авсан. | 90 |
| **Зорилт 3.2** | **Бэлчээр ашиглалтыг сайжруулах, мал сүргийн усан хангамжийг нэмэгдүүлэх, хортон мэрэгчтэй тэмцэх ажлын зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.** | 557.0 | Усжуулагдсан бэлчээрийн талбай, малын тоо | 290.0 гаруй мянган толгой мал 70.7 мянган га бэлчээрийг усжуулсан | - | -84.0 мян. тол мал -42.0 мян.га талбай | Аймгийн хэмжээнд нийт 1181 худаг байгаагаас 1029 бэлчээрийн худаг, ундны усны худаг 110, засварлах шаардлагатай 42 худаг байна. Үүнээс бэлчээрийн худгаас инженерийн хийцтэй гүн өрмийн 933 худаг, энгийн уурхайн 96 худаг ашиглагдаж байгаагаас 996 худаг буюу нийт худгийн 89.7 хувийг ашиглаж, нийт өрхийн буюу 96.0 хувь нь усаар хангагдсан байна. | **85** |
| 3.2.1 | Сумдад худаг гаргах | 575.0 | Худгийн тоо | 47 худаг | - | 19 худаг | 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 5 худаг шинээр, Эрдэнэмандал, Хашаат, Цэнхэр, Хайрхан сум 26 худгийн цооног гаргаж, Өгийнуур сум 4 худгийг засварлаж, нийт 35 худгийг ашиглалтад оруулснаар 280 өрхийн 105,0 мянган толгой мал, 63,0 мянган га бэлчээрийг усжууллаа. Сумдын Засаг дарга нарт малын тоо толгойн албан татварын орлогоор худаг гаргахад мэргэжлийн байгуллагуудаас техникийн тодорхойлт авч тендер зарлах, хяналт тавьж ажиллах чиглэл өгсөн. Сумдад худаг гаргах ажилд хяналт тавих ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж ажилласан. | 100 |
| 3.2.2 | Бэлчээр ашиглалтыг сайжруулах, хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангах | - | -Хортонтой тэмцсэн га талбай<br>-Гарсан шийдвэрийн тоо | -40.0 мян.га<br>-2 | -30.0 мян.га<br>-1 | -30.0 мян.га | 2022 онд бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготнотой микробиологийн аргаар тэмцэх ажлыг малын тоо толгойн татварын орлогоор Цэнхэр, Хангай, Цахир, Өгийнуур сумдын 12 багийн 4550 га талбайд 104 малчны | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оролцоотойгоор, Чулуут, Хайрхан сум энгийн механик, биологийн аргаар 26 малчны оролцоотойгоор 5005 га-д тэмцэх арга хэмжээ зохион байгуулж 82,8 хувийн үр дүнтэйгээр тэмцсэн байна. Нийт 9555 га бэлчээрт үлийн цагаан оготнотой энгийн механик болон микробиологийн аргаар тэмцэх ажлыг зохион байгууллаа. Малын тоо толгойн албан татварын орлогоос мал аж ахуйн салбарт зарцуулах чиглэлийг сумдын Засаг дарга нарт өгсөн. | |
| 3.2.3 | Малын гоц халдварт, халдварт, паразит өвчинтэй тэмцэх ажлыг зохион байгуулж, малын өвчлөлийг бууруулна. | 670.0 | Халдварт, паразит өвчний бууралтын хувь | 20 | - | 23 | 2021 оны мөн үетэй харьцуулахад халдварт өвчний гаралт 40 хувиар буурсан байна. | 90 |
| 3.2.4 | Малын гоц халдварт, халдварт, паразит өвчинтэй тэмцэх ажлыг зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөх, холбогдох шийдвэрийг гаргуулах | 670.0 | Хамрагдсан малын тоо | 1214.8 мянга /халдварт / 7196.9 мянга /паразит/ | 700.0 мянга | 1214.8 мянга /халдварт / 7196.9 мянга /паразит/ | Цусан халдварт, дотрын халдварт хордлого, дуут хавдар, гахайн цусан халдварт, шөвөг яр, сахуу, сохор догол зэрэг 7 нэр төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг татан авч, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид хуваарийн дагуу олгож, 1754,0 мянган толгой мал хамруулсан. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын яаралтай дархлаажуулалтад аймгийн нийт 590489 үхэр, 1247 гахайг, намрын дархлаажуулалтад 13,4 мянган өрхийн 908,9 мянган үхэр, 1824 гахай, нийт 910,7 мянган мал, амьтан хамруулсан нь 97,3 хувьтай байна. Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх угаалга, туулгалт, боловсруулалт, үхрийн арьсны гуурын боловсруулалтын арга хэмжээнд нийт 5400.0 мянган толгой мал хамруулахаар төлөвлөснөөс туулгалтад 1603.0 мянган толгой мал, боловсруулалтад 631.0 мянган толгой мал, үхрийн арьсны гуурын боловсруулалтад 636.0 мянган толгой мал, мал угаалганд 3262.8 мянган толгой мал хамруулж, нийт 6132.8 мянган толгой малыг хамруулсан. 2022 онд гарсан шүлхий, мялзан өвчний үед мэргэжлийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгууллагууд, аймгийн онцгой комисстой хамтран зохион байгууллалтын арга хэмжээг авч ажилласан. | |
| **Зорилт 3.3** | **Орон нутгийн иргэд хүнсний ногоо, жимс жимсгэний хэрэгцээгээ өөрөө хангах, зоорь, хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжиж, “Өрхийн тариалан” арга хэмжээг хэрэгжүүлнэ.** | 218.0 | Төмс, хүнсний ногооны дотоодын үйлдвэрлэлийн хангамж хувиар | -Төмс 56 % -Хүнсний ногоо 23 % | - | Төмс 58.0% -Хүнсний ногоо 25 % | Аймгийн хэмжээнд нийт 2230 тн багтаамж бүхий зоорь ашиглагдаж байна. Өрхийн тариалан хөтөлбөрийн хүрээнд 400 өрхөд 2.6 тн хүнсний ногооны үрийг хөнгөлөлттэй үнээр олгосон. 2022 онд 166 га-д хүнсний ногоо, 275 га-д төмс тариалсан. 2022 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хүн амын нийт хэрэгцээт төмсний 42 хувийг, хүнсний ногооны 17.4 хувийг дотоодоосоо хангаж байна. /энэ жилийн нийт ургацын хэмжээ буурсан/ | **85** |
| 3.3.1 | Эрдэнэбулган сумдад төмс, хүнсний ногооны механикжсан зоорь барих ажлын зохион байгуулах | 180.0 | Зоорийг барилгын ажлын явц хувиар | Шинээр тооцно | 10 | 100 | Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл, Таруугийн гол хоршооны хамтарсан хөрөнгө оруулалтаар 50 тн багтаамжтай хүнсний ногооны зоорийн барилгын ажлыг ”Идум” ХХК гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгсөн. Тус зоорийг Таруугийн гол хоршоонд 5 жилийн хугацаанд ашиглах ашиглалтын гэрээг байгуулаад байна. | 100 |
| 3.3.2 | “Өрхийн тариалан” хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 38.0 | Хөтөлбөрийн хэрэгжилт хувиар | Шинээр тооцно | 10 | 100 | “Өрхийн тариалан” хөтөлбөрийг 2021 онд аймгийн ИТХ-аар батлуулан, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, сум, агентлагт хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд хөтөлбөрийн хүрээнд иргэдэд мэдээ мэдээлэл өгөх ажлыг сумын Хөдөө аж ахуйн тасгаар дамжуулан зохион байгуулж, 400 өрхөд 15,2 сая төгрөгийн 2.6 тн хүнсний ногооны үрийг хөнгөлөлттэй үнээр олгож, нийт 690 өрхийг хамруулан 115,2 га-д тариалж, 880 тн ургац хураан авсан. Хөтөлбөрийн хэрэгжилт 52.8 хувьтай байна. | 70 |
| **Зорилт 3.4** | **Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэлийг бүрэн хангуулна** | 70.0 | Бэлтгэл ажлын хувиар | 88.5 % | - | 88 | 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл аймгийн хэмжээнд 92 хувьтай байна. | **100** |
| 3.4.1 | Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг зохион байгуулах | 40.0 | Аймаг, сумын өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, | Холбогдох шийдвэр | - | Албан даалгавар, захирамж, | Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангуулах тухай Монгол улсын Засгийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | отор нүүдлийн талаар авах арга хэмжээг төлөвлөсөн байна. | үүдийг гаргуулан , зохион байгуулс ан. | | УОК, ХХААХҮЯ-нд хүсэлт хүргүүлсэн байна. | газрын 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 277 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 09 дүгээр албан даалгаврын дагуу аймгийн Засаг дарга А/557 дугаар захирамж, Өвөлжилтийн бэлтгэл хангах тухай 04 тоот албан даалгаварын гаргаж өвөлжилтийн бэлтгэл хангуулах арга хэмжээг орон нутагт зохион байгуулан ажилласан. Улсын онцгой комисс, ХХААХҮЯ-нд 2 удаагийн санал хүсэлтийг хүргүүлсэн. Аймгийн мал хамгаалах сангаас 10000 боодол ногоон тэжээл, 800 шуудай ашигт долооцыг өвөлжилт хүндэрсэн 8 суманд хөнгөлөлттэй үнээр олгох ажлыг зохион байгуулж байна. | |
| **Зорилт 3.5** | **Малчдыг урамшуулах, мал маллагааны арга туршлагыг сурталчлах ажлыг зохион байгуулна** | - | “Улс, аймгийн аварга малчин”-аар шалгарсан малчдын тоо | 149 малчин | 110 малчин | - | Улс, аймгийн аварга малчин, аварга саальчин, аварга фермерээр 117 малчин тодорлоо. | **100** |
| 3.5.1 | “Улсын аварга малчин”, “Улсын аварга сальчин”, “Улсын аварга фермер“-ээр шалгаруулахаар тодорхойлсон малчдын ажлын үзүүлэлтийг эрэмбэлж аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ХХААХҮЯ-нд уламжлах | - | Улсын аварга малчин өрхөд уламжилсан малчдын тоо | 15 малчин | 7 малчин | - | “Улсын аварга малчин”, “Улсын аварга сальчин”, “Улсын аварга фермер“-ээр шалгаруулахаар тодорхойлсон малчдын ажлын үзүүлэлтийг эрэмбэлж аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 15 малчны материалыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлснээр, 6 Улсын аварга малчин”, 1“Улсын аварга сальчин”, 1 “Улсын аварга фермер”тодорлоо. | 100 |
| 3.5.2 | “Аймгийн аварга малчин”, “Аймгийн аварга сальчин”, “Аймгийн аварга фермер“, “Аймгийн аварга тариаланч”-аар шалгаруулах ажлыг зохион байгуулах | 20.0 | Шалгаруулсан малчдын тоо | 110 малчин | 100 малчин | - | “Аймгийн аварга малчин”, “Хошой аварга малчин”-аар 110, “Аймгийн аварга сальчин”-11 малчинг, “Аймгийн аварга тариаланч”-1 аж ахуйн нэгжийг шалгаруулах ажлыг зохион байгууллаа. | 100 |
| **Зорилт 3.6** | **“Архангай түншлэл” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулна** | 5.0 | Оролцогчдын тоо Борлуулалтын орлого | 95 87сая | - | 97 90сая | “Архангай түншлэл-2022” үзэсгэлэн худалдааг 2022 оны 09 дүгээр сарын 29, 30-ны өдрүүдэд зохион байгууллаа. Үзэсгэлэнд Эрдэнэбулган, Өндөр-улаан, | **90** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Жаргалант, Хашаат, Ихтамир, Чулуут, Тариат, Хайрхан, Хангай, Эрдэнэмандал, Батцэнгэл, Өгийнуур Өлзийт, Хотонт, Цэнхэр, Цэцэрлэг, Төвшрүүлэх, Булган, Цахир 19 сум, Улаанбаатар, Дархан, Сэлэнгэ, Завхан аймгуудын нийт 177 аж ахуй нэгж, иргэд төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн, модон эдлэл, бэлэн хувцас, гар урлалын бүтээгдэхүүн, эсгий ноосон бүтээгдэхүүн зэрэг 10 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг худалдаалж 117.6 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. | |
| 3.6.1 | Улсын болон бусад аймгийн үндэсний үйлдвэрлэл эрхлэгчдийг үзэсгэлэн худалдаанд оролцуулах, харилцан туршлага солилцох мөн сумдын жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлнэ | - | Сумаас оролцогчдын тоо | 10 сум | - | 15 сум | “Намрын ногоо өдрүүд” нэгдсэн арга хэмжээнд сүү цагаан идээгээр 17 аж ахуй нэгж, иргэн оролцож 69,3 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. | 90 |
| **Зорилт 3.7** | **Орон нутгийн онцлогийг шингээсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг сангийн болон бусад зээлийн бодлогоор дэмжих** | 1.000.0 | -Зээл олгосон аж ахуй нэгж, иргэний тоо<br>-Нэмэгдсэн ажлын байрны тоо | 8<br><br>97 | - | 5-8 аж ахуй нэгжид 10-20 ажлын байр нэмэгдүүлэх | ХХААХҮ-ийн сайдын 2022 оны А/168 дугаар тушаалаар батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн төслийг хүлээн авах үйл ажиллагааг 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс орон даяар нэгэн зэрэг авч эхэлсэн. 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс 2022 оны 07 сарын 07-ны өдрийг хүртэл цахимаар хүлээн авсан бөгөөд нийт 10 төсөл бүртгүүлснээс 3 төсөл хүчингүй болж хасагдсан, Программд оруулсан 7 төслөөс шаардлага хангасан 3 төслийг төсөл сонгон шалгаруулах дэд хорооны хурлаар хэлэлцэн ЖДҮГазарт хүргүүлж 550.0сая төгрөгийн зээл олгогдоод байна. 2022 онд Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд 12 сумын 59 хоршоо, аж ахуйн нэгж, | **100** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | иргэний төсөлд 1.9тэрбум төгрөгийн зээлийг тус тус олгож 199 ажлын байр бий болсон байна. Мөн дэлхийн чанарын өдрийг тохиолдуулан орон нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг урамшуулах зорилгоор зохион байгуулсан арга хэмжээнд шинэ технолгоор брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгч “Уламбаяжихуй” ХХК-ны гурил гурилан бүтээгдэхүүнийг шалгаруулж 1500.0мянган төгрөгөөр шагнуулсан байна. | |
| 3.7.1 | Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах, санд хүргүүлэх зэрэг ажил зохион байгуулна | - | Зохион байгуулсан ажлын гүйцэтгэлийн хувь | - | - | 100 | ХХААХҮ-ийн сайдын 2022 оны А/168 дугаар тушаалаар батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн төслийг хүлээн авах үйл ажиллагааг 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс орон даяар нэгэн зэрэг авч эхэлсэн. 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс 2022 оны 07 сарын 07-ны өдрийг хүртэл цахимаар хүлээн авсан бөгөөд нийт 10 төсөл бүртгүүлснээс 3 төсөл хүчингүй болж хасагдсан, Программд оруулсан 7 төслөөс шаардлага хангасан 3 төслийг төсөл сонгон шалгаруулах дэд хорооны хурлаар хэлэлцэн ЖДҮГазарт хүргүүлж 550.0сая төгрөгийн зээл олгогдоод байна. 2022 онд Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд 12 сумын 59 хоршоо, аж ахуйн нэгж, иргэний төсөлд 1.9тэрбум төгрөгийн зээлийг тус тус олгож 199 ажлын байр бий болсон байна. | 100 |
| 3.7.2 | Хоршоог сурталчлах, шилдэг туршлагыг дэлгэрүүлэх хоршооны гишүүд, сумын мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулна | - | Гүйцэтгэлийн хувь | - | 100 | 100 | Монгол Улсад хоршооллын салбар үүсч хөгжсөний 100 жил, Засгийн газрын 2021 оны 238 дугаар тогтоолыг үндэслэн хоршоог сурталчлах, хоршооны тухай хууль, хоршоо хөгжүүлэх журмыг таниулах, тэргүүн туршлагыг дэлгэрүүлэх, ажлыг улсын хэмжээнд өрнүүлж, ойн арга хэмжээний хүрээнд чадавхжуулах | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалтыг энэ онд 2 удаа зохион байгуулсан. Сургалтад сумдын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн болон хоршооны төлөөллийг нийт 180 гаруй иргэд хамрагдлаа. | |
| **Зорилт 3.8** | **“Малчин эмэгтэйчүүд ба аюулгүй хүнс” арга хэмжээг хэрэгжүүлнэ** | - | Гүйцэтгэлийн хувь | - | - | 50 | НҮБ-ын хөгжлийн хөтөлбөртэй хамтран” Малчин эмэгтэйчүүд ба аюулгүй хүнс хөтөлбөр” боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болсон байна. “Хуванцар хэрэглээ ба хүнсний аюулгүй байдал” сургалтыг Хасу, Архангайд үйлдвэрлэв худалдааны төвийн сүү цагаан идээний худалдаа эрхлэгчдэд, Эрдэнэмандал, Чулуут, Хангай, Тариат, Цахир, Өндөр-Улаан, Ихтамир сумын 60 гаруй саальчин бүсгүйчүүдэд “Хүнсний аюулгүй сав” сургалтыг тус тус зохион байгууллаа.<br>Мөн 45 малчин өрхөд тус бүрд 7 нэр төрлийн хүнсний зориулалтын савыг сургалтын үеээр гардууллаа. | **70** |
| 3.8.1 | “Малчин эмэгтэйчүүд аюулгүй хүнс” хөтөлбөр боловсруулна | 50.0 | Хувь | 10 | - | 50 | “Малчин эмэгтэйчүүд ба аюулгүй хүнс” хөтөлбөрийг боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болсон байна. | 70 |
| БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ | | | | | | | | |
| АХЖТ-ний 3.3. Орон нутгийн онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй , нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ. | | | | | | | | |
| **Зорилт 3.9** | **Архангай аймгийн аялал жуулчлалын салбарыг олон нийтэд сурталчилж, аялал жуулчлалын салбарыг цахимжуулж, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний тоог нэмэгдүүлнэ** | | Цахим аялал жуулчлал арга хэмжээний хэрэгжилт | | | | Голомт банк, “Public lab Mongolia” ТББ-тай хамтран аймгийн аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, худалдаа, эмийн сан, шатахуун түгээх станц, банк зэрэг 1100 газрын мэдээллийг цахимжуулж, Open street map-д оруулаад байна. Мөн "Архангай аймгийн зочлох үйлчилгээний цахим шилжилт" сургалтыг 2 удаа онлайнаар зохион байгуулж, Эрдэнэбулган, Тариат, Хайрхан, Өгийнуур сумдад үйл ажиллагаа явуулж буй жуулчны бааз, зочид буудал, гэр буудал, дэн буудлын 26 аж ахуйн нэгж, байгууллагын | **90** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Мэдээлэл авсан иргэдийн тоо | | | | захирал, менежер, зохион байгуулагч, нягтлан бодогчдын төлөөлөл хамрагдлаа. Тайлант хугацаанд давхардсан тоогоор 17 жуулчны бааз, 1 зочид буудал Myhotel, Horecasoft, Joinme зэрэг онлайн захиалгын платформд мэдээллээ байршуулаад байна. Тайлант хугацаанд Архангай аймгийн аялал жуулчлалын салбарыг сошиал хуудас, Feel Mongolia гар утасны апликейшнаар 200 000 орчим, цаасан хэлбэрээр 25000 орчим хүнд сурталчилсан бол Myhotel, Horecasoft, Joinme зэрэг онлайн захиалгын платформд 17 жуулчны бааз, 1 зочид буудал мэдээллээ байршуулж 500 орчим ор хоногийг онлайн захилгаар худалдсан байна. | |
| 3.9.1 | “Цахим аялал жуулчлал” арга хэмжээг хэрэгжүүлнэ | БХНСАХ 3-150.0 | Хэрэгжилтийн хувь | - | | 70 | Архангай аймгийн аялал жуулчлалын газар зүйн мэдээллийн санг үүсгэх төслийн танилцуулга, мэдээлэл цуглуулах зааварчилгааг “Public lab Mongolia” ТББ-тай хамтран 19 сумын төлөөллүүдэд онлайнаар 06 сарын 10-ны өдөр өгсөн бөгөөд 14 хоногийн хугацаанд мэдээллүүдийг цуглуулж Dashboard-д байрлуулсан бөгөөд 06 сарын 30, 07 сарын 01-ний өдрүүдэд дээрх мэдээллийг нягталж, Open street map-д оруулахад бэлэн болголоо. Энэхүү ажлын хүрээнд нийтдээ 1078 мэдээллийг нэгтгэлээ. | 100 |
| 3.9.2 | Олон Улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох | Улс, орон нутгийн төсөв | Оролцсон үзэсгэлэнгийн тоо Мэдээлэл хүргэсэн | ITM аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцож хэвшсэн | | 1-доошгүй үзэсгэлэнд оролцож 10 мянгаас доошгүй хүнд сурталчилсан байна | 2022 оны 05 дугаар сарын 27-оос 29-ний өдрүүдэд дотоодын аялагчдад зориулсан үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэн Улаанбаатар травэл экспод оролцож давхардсан тоогоор 5000 гаруй хүнд мэдээлэл өгч, гарын авлага материал тараасан байна. Аймгийн аялал жуулчлалын маршрутыг сурталчлах зорилгоор “Жим” сэтгүүлд аялал жуулчлалын мэдээлэл өглөө. Мөн “Аялан тухлах Арын сайхан хангай” нэгдсэн танилцуулгыг шинэчлэн 1500ш-ийг хэвлүүллээ. 10 сарын 28-30-ны өдрүүдэд УБ хотын Мишээл экспо төвд Архангай | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | аймгийн “Эртний нүүдэлчдийн өлгий” аялал жуулчлалын холбоотой хамтран 72$м^2$ талбайд “Ялгамж брэнд” ТББ-аар талбайн дизайнаа гаргуулж, аймгийн аялал жуулчлалын брэндийг таниулах зорилготойгоор оролцож, аймаг орон нутгаа сурталчиллаа. Үзэсгэлэнгийн өдрүүдэд Архангай аймгийн талбайгаар 6500 орчим хүн зочилж, архангай аймгийн нэгдсэн мэдээлэл бүхий 1450 гарын авлага материал, жуулчны баазуудын танилцуулга мэдээлэл бүхий 6000 орчим гарын авлага материал тарааж, 20 аж ахуйн нэгж нийтдээ 150 гэрээ үзэглэж, үзэсгэлэнгийн шилдэг стэндээр шалгарсан амжилттай оролцлоо. | |
| 3.9.3 | Архангай аймгийн “Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө”-г боловсруулан хэрэгжүүлэх | БХНСАХ 3-90000 | Төлөвлөгөөг батлуулсан байна. | - | | Төлөвлөгөөг боловсруулж, батлуулна | Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх цогц арга хэмжээг боловсруулах ажлыг “Мирим консалтант” ХХК 70%-тайгаар гүйцэтгэж байна. Гэрээний хугацаа дууссан тул гэрээг нэмэлтээр сунгаж 12 дугаар сарын 30-нд ажлыг дуусгаж, хүлээж авна. | 70 |
| **Зорилт 3.10** | **Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлнэ** | Улс, орон нутгийн төсөв | Тарьсан модны тоо<br>Оролцсон сумдын тоо<br>Бэлтгэсэн тарьц суулгацын тоо<br>Ойн бүрхэвч бий болгосон га талбайн хэмжээ | | | 90-100 ширхэг мод бутыг тарьж ургуулсан. 1000-с доошгүй тарьц суулгац бэлдсэн байна. 19 сум бүрэн оролцоотой ажилсан байна | 2022 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 497016 ширхэг мод, бут сөөгийг үр, мөчрөөр 19 сумын хэмжээнд тарьж, Цэнхэр, Булган, Ихтамир, Өгийнуур, Эрдэнэбулган, Эрдэнэмандал, Хотонт суман дахь 65 га мод үржүүлгийн талбайд тарьц, суулгацын нөөц бүрдүүлэхээр хүлэмж болон ил талбайд навчит, шилмүүст модны 50 кг үр, 300.0 мянга гаруй мөчрөөр тарилт хийж, 60 кг шинэсний цэвэр үрийг түүж, усалгаа, арчилгааны ажлыг технологийн дагуу хийж гүйцэтгүүллээ. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хөрс, байгалийн бүс бүслүүрийн онцлогийг харгалзан үзэж 4 суманд 13 га талбайд шинээр мод үржүүлгийн талбайг байгууллаа. | **100** |
| 3.10.1 | Шилмүүст болон навчит модны тарьц, суулгацын нөөцийг нэмэгдүүлэх, үр бэлтгэх байнгын болон | - | Бэлтгэсэн тарьц суулгацын тоо | 2021 онд 700 ширхэг тарьц | | 1000-с доошгүй тарьц суулгац | Цэнхэр, Булган, Ихтамир, Өгийнуур, Эрдэнэбулган, Эрдэнэмандал, Хотонт суман дахь 65 га мод үржүүлгийн талбайд тарьц, суулгацын нөөц бүрдүүлэхээр | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | түр талбайг байгуулж, арчлах, үрийн нөөцийг бүрдүүлэх | | | суулгацы г бэлтгэсэн | | бэлдсэн байна | хүлэмж болон ил талбайд навчит, шилмүүст модны 50 кг үр, 300.0 мянга гаруй мөчрөөр тарилт хийж усалгаа, арчилгааны ажлыг технологийн дагуу хийж гүйцэтгүүллээ. Мод үржүүлгийн газруудын талбайд 1 настай 10 гаруй төрөл зүйлийн 629.0 мянган ширхэг тарьц суулгацын нөөцийг бүрдүүлж ажиллалаа. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хөрс, байгалийн бүс бүслүүрийн онцлогийг харгалзан үзэж Хайрхан суманд 7 га, Чулуут суманд 2 га, Хангай суманд 3 га, Цэнхэр суманд 1 га талбайд шинээр мод үржүүлгийн талбайг байгууллаа. Шилмүүст модны үрийн ургалт, болц гүйцэх үеийн судалгааг тогтмол гүйцэтгэж, Сум дундын ойн ангиудтай хамтран “Нэг байгаль хамгаалагч-50 кг шинэсний боргоцой” түүх аяныг өрнүүлж аймгийн хэмжээнд 60 кг шинэсний цэвэр үрийг түүж, 2023 оны хавар мод үржүүлгийн газарт тарих нөөцийг бий болголоо. | |
| 3.10.2 | Байгаль, цаг уурын онцлогт тохирсон шилмүүст болон навчит, жимс жимсгэнийн модыг тарьж ургуулах. | - | Тарьж ургуулсан модны тоо | | | 90-100 мянган мод , бут сөөгийг тарьж ургуулсан байна. | 2022 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 497016 ширхэг мод, бут сөөгийг үр, мөчрөөр болон ногоон байгууламж бий болгох, нэмэгдүүлэх, ойн нөхөн сэргээлт, хамгаалалтын ойн зурвас байгуулахад шилмүүст, навчит төрлийн суулгацыг тарьж, усалгаа, арчилгааны ажлыг гүйцэтгүүллээ. Нийт мод үржүүлгийн газарт тарьж бойжуулсан тарьц, ойн нөхөн сэргээлт, ойн зурвас байгуулах, нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид тарьж Цэнхэр, Булган, Ихтамир, Өгийнуур, Эрдэнэбулган, Эрдэнэмандал, Хотонт суман дахь 65 га мод үржүүлгийн талбайд тарьц, суулгацын нөөц бүрдүүлэхээр хүлэмж болон ил талбайд навчит, шилмүүст модны 50 кг үр, 300.0 мянга гаруй мөчрөөр тарилт хийж усалгаа, арчилгааны ажлыг технологийн дагуу хийж гүйцэтгүүллээ. 13670 ширхэг жимс, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | жимсгэнийн суулгацыг иргэд тарьж ургуулж байна. | |
| **Зорилт 3.11** | **Аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэх** | - | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | | | Хэрэгжилтийн хувийг 25 хувьд хүргэнэ | 2022 онд 19 сумын Засаг дарга нарт хүргүүлж, хөтөлбөрийг хэрэгжилтийг ханган ажиллалаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 4 зорилт 27 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 498,4 сая төгрөгийг төсөвлөснөөс 110,1 сая төгрөг зарцуулсан байна. Хөтөлбөрийн хэрэгжилт 70 хувьтай байна. | **75** |
| 3.11.1 | "Гуравдугаар зэрэглэлийн хог хаягдлын төвлөрсөн цэг"-ийн ерөнхий шаардлагын хэмжээнд байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр газарт булшилж хадгалах байгууламжийг бий болгох. | - | Гуравдугаар зэрэглэлийн хогийн цэгийн тоо | 1 | 1 | 1-с доошгүй хогийн цэгийг гуравдугаар зэрэглэлийн хогийн цэгийн шаардлагад нийцүүлнэ | Чулуут сумын хогийн цэгийг гуравдугаар зэрэглэлийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн стандартын шаардлагад нийцүүлэх ажлыг "Газрын гагнаас" ХХК гүйцэтгэж Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 19-ны А/71 тушаалаар байгуулагдсан комисс ажлыг хүлээж авсан. /Орон нутгийн хөгжлийн сангийн 120 сая төгрөгөөр 25 га талбайг 5 га хүртэл багасгаж буурулсан/. Өндөр-Улаан сумын хуучин хогийн цэгийг дээш нь шууж янзлаад, хажуу талд нь шинээр цооног ухаж, торон хашаа, камер суурилуулсан. /Сумын орон нутгийн хөгжлийн сангийн 70 сая төгрөгөөр 4га талбайг 2га хүртэл бууруулсан./ | 100 |
| 3.11.2 | Сумдын "Хог хаягдлын төвлөрсөн цэг"-ийн талбайн хэмжээг багасгах | - | Хог хаягдлын цэгийн талбай хэмжээ /га/ | Аймгийн хэмжээнд хогийн цэг 144,9 га талбайг эзэлж байна | | Хогийн цэгийн га талбайг 140 га болгосон байна | Эрдэнэбулган, Хашаат, Өгийнуур, Хотонт, Батцэнгэл, Өндөр-Улаан, Цахир, Цэнхэр, Чулуут зэрэг сумдад нэгдсэн хогийн цэгийг дотогш түрж хумих, хамгаалалтын хашаа, даланг янзлах ажлыг хийж гүйцэтгэж хогийн цэгийн га талбайг 31,6 га талбайгаар бууруулсан байна. Тариат, Хайрхан, Ихтамир, Өгийнуур, Цахир, Жаргалант, Чулуут, Эрдэнэбулган зэрэг сумдад хог хаягдал дахин боловсруулах, ангилан ялгах, эдийн засгийн эдийн засгийн эргэлтэд оруулах дахивар авдаг нийт 12 иргэн байна. | 50 |
| ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ДЭД БҮТЭЦ | | | | | | | | |
| АХЖТ-ний 3.4. Аймаг, сумдын газар зохион байгуулалт, хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 3.12** | **Улсын чанартай авто замын ойролцоох сумдыг хатуу хучилттай замаар холбох ажлыг үе шаттай зохион байгуулахаас гадна орон нутгийн шаардлагатай зам, гүүрний ажлыг ээлж дараатай хийж гүйцэтгэнэ** | - | Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь | - | 10 | 30 | Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн авто замын санд 2022 онд 986.0 сая төгрөгийг төвлөрүүлж, орон нутгийн чанартай авто замын 10 төсөл арга хэмжээнд Авто зогсоол байгуулах, Эрдэнэбулган сум доторх хатуу болон хайрган хучилттай авто замын засвар арчлалт, тэмдэг тэмдэглэгээ, Булган сумын Тусгалт багийн Хавтгайн модон гүүр барих, Эрдэнэбулган сумын 6 дугаар багийн Элстэй гол дээр модон гүүр барих, Цахир сумын төв доторх бетон хучилттай авто зам барих, Хангай сумын давааны авто замын засвар, Эрдэнэбулган сумын 2 дугаар баг Арслан цохио чиглэлийн авто зам, Цагаан давааны ганц модны орчим ослын зогсолтын талбай байгуулах, Цэнхэр сумын хатуу хучилттай авто зам, Жаргалант сумын модон гүүр засварлах ажлуудыг хугцаандаа бүрэн дууссан Улсын комисст хүлээн аваад байна. | **91,1** |
| 3.12.1 | Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр, авто замын ажлын эхлэл, 63 км үргэлжлүүлнэ | 62.000.0 | Барилгын гүйцэтгэлийн хувь | 41.8 | 50 | Авто зам, барилгын ажлыг 55%-д хүргэх | Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр, 63 км авто замын барилгын гүүр хоолой ажил бүрэн дууссан авто замын далангийн ажил 85 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж нийт барилгын ажил 72 хувийн гүйцэтгэлтэй он дамжин хэрэгжиж байна. | 100 |
| 3.12.2 | Өндөр-Улаан сумын төвийн 7 км хатуу хучилттай авто замын барилга угсралтын ажлыг үргэлжлүүлнэ | 6.300.0 | Барилгын гүйцэтгэлийн хувь | 15 | 50 | Авто зам, барилгын ажил 80%-д хүргэх | Өндөр-Улаан сумын Бэлх багаас сумын төв хүртэлх 7 км хатуу хучилттай авто зам, барилгын ажлын гүүр хоолойн барилгын ажил 100%, авто замын далангийн ажил бүрэн дууссч хучилт хийх ажил үлдсэн байна. Нийт барилгын ажил 83 хувийн гүйцэтгэлтэй он дамжин хэрэгжиж байна. | 100 |
| 3.12.3 | Хархорин-Цэцэрлэг чиглэлийн А0602 дугаартай авто замаас Өгийнуур- Батцэнгэл-Ихтамир чиглэлийн А27 дугаартай мянганы замын хэвтээ тэнхлэгийн авто зам хүртэлх 7 км | 6.200.0 | Барилгын гүйцэтгэлийн хувь | - | 15 | Авто зам, барилгын ажил 40%-д хүргэх /2022 онд 1.6 тэрбум/ төгрөг | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хархорин-Цэцэрлэг чиглэлийн А0602 дугаартай авто замаас Өгийнуур-Батцэнгэл-Ихтамир чиглэлийн А27 дугаартай мянганы замын хэвтээ тэнхлэгийн авто зам чиглэлийн 14 км авто замын гүүр хоолойн барилгын ажил бүрэн дууссан, авто замын далангийн барилгын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | авто замын ажлын 2 дугаар хэсэг, үе шаттай эхлүүлнэ | | | | | | ажил бүрэн дууссан хучилтын ажил үдсэн байна нийт 80 хувийн гүйцэтгэлтэй он дамжин хэрэгжиж байна. | |
| 3.12.4 | Өндөр-Улаан багийн Донгой багаас Чулуут сум хүртэлх 65.8 км хатуу хучилттай авто замын ажлыг үе шаттай эхлүүлнэ | 39.500.0 | Барилгын гүйцэтгэлийн хувь | - | 15 | Авто зам, барилгын ажлыг 30%-д хүргэх /2022 онд 14.0 тэрбум/ төгрөг | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Өндөр-Улаан багийн Донгой багаас Чулуут сум хүртэлх хатуу хучилттай 65.8 км авто замын барилгын ажлыг Орон нутгийн өмчийн газар тендер зарлагдан гэрээ байгуулж эхний 6 км авто замын далангийн ажил хийгдээд байна. Энэ ажил он дамжин хэрэгжиж байна. | 100 |
| 3.12.5 | Тариат сумын төв доторх хатуу хучилттай авто замын ажлыг үе шаттай эхлүүлнэ | 2.500.0 | Барилгын гүйцэтгэлийн хувь | - | 15 | Авто зам, барилгын ажлыг 35%-д хүргэх /2022 онд 800.0 сая/ төгрөг | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Тариат сумын төвийн хатуу хучилттай авто замын барилгын ажлын далангийн суурийн ажил хийгдэж он дамжин хэрэгжиж байна. | 70 |
| 3.12.6 | Хангай сумын төв доторх хатуу хучилттай авто замын ажлыг үе шаттай эхлүүлнэ | 2.500.0 | Барилгын гүйцэтгэлийн хувь | - | 15 | Авто зам, барилгын ажлыг 35%-д хүргэх /2022 онд 800.0 сая/ төгрөг | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хангай сумын төвийн хатуу хучилттай авто замын барилгын ажил эхлээд байна. Энэ ажил он дамжин хэрэгжиж байна. | 70 |
| 3.12.7 | Хайрхан сумын Хануйн голын төмөр бетон гүүрний барилгын угсралтын ажлыг дуусгана | 3.500.0 | Барилгын гүйцэтгэлийн хувь | 10% | 15 | Төмөр бетон гүүрний барилгын ажлыг 100%-д хүргэх | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар Хайрхан сумын Хануйн голын төмөр бетон гүүрийн барилгын ажлын завсрын тулгуурын ажил 60% дам нурууны цутгалтын ажил бүрэн дууся 65 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ онд дуусах байсан боловч төсөвт өртөг он дамжин хэрэгжихээр болсон. | 90 |
| 3.12.8 | Тариат сумын Мөрөн багийн Дасгалын 35у/м төмөр бетон гүүрний барилгын угсралтын ажлыг дуусгана | 1.600.0 | Барилгын гүйцэтгэлийн хувь | - | 15 | Төмөр бетон гүүрний барилгын ажлыг | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Тариат сум, Мөрөн багийн Дасгалын 35 у/м төмөр бетон гүүрийн барилгын ажил 92 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Үүнээс дам нуруу, тулгуурын цутгалтын ажил 100 хувь хийгдсэн, зорих хэсгийн | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 100%-д хүргэх | ажил хийгдэж байна. энэ онд дуусгахаар төлөвлөн ажиллаж байна. | |
| 3.12.9 | Цэцэрлэг хот доторх хатуу болон хайрган хучилттай авто замын засвар арчлалт хийнэ | 769.0 | Барилгын гүйцэтгэлийн хувь | - | 30 | Авто замын засварын ажил бүрэн хэрэгжсэн байна | Орон нутгийн авто замын санд 2022 онд 986.0 сая төгрөгийг төвлөрүүлж, орон нутгийн чанартай авто замын 10 төсөл арга хэмжээнд Авто зогсоол байгуулах, Эрдэнэбулган сум доторх хатуу болон хайрган хучилттай авто замын засвар арчлалт, тэмдэг тэмдэглэгээ, Булган сумын Тусгалт багийн Хавтгайн модон гүүр барих, Эрдэнэбулган сумын 6 дугаар багийн Элстэй гол дээр модон гүүр барих, Цахир сумын төв доторх бетон хучилттай авто зам барих, Хангай сумын давааны авто замын засвар, Эрдэнэбулган сумын 2 дугаар баг Арслан цохио чиглэлийн авто зам, Цагаан давааны ганц модны орчим ослын зогсолтын талбай байгуулах, Цэнхэр сумын хатуу хучилттай авто зам, Жаргалант сумын модон гүүр засварлах ажлуудыг хугцаандаа бүрэн дууссан улсын комисст хүлээн аваад байна. | 100 |
| **Зорилт 3.13** | **Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх эрх шилжсэн төсөл арга хэмжээг хугацаанд нь чанартай зохион байгуулж гүйцэтгэлийн хяналт тавьж, эрх нээж ажиллана** | Улсын төсөв 87.922.4 Орон нутгийн төсөв 3.615.0 | Гүйцэтгэлийн хувь | - | - | 100 | 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 51.527,8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 55 төсөл арга хэмжээ батлагдсанаас аймагт 25,383,2 сая төгрөгийн нийт 54 төсөл арга хэмжээ эрх шилжиж ирсэн бөгөөд жилийн эцсийн байдлаар 18,703,9 сая төгрөгийн санхүүжилтийг хянаж тайлагнаж ажиллалаа Санхүүжилтийн явцыг тухай төсвийн хөрөнгө оруулалтын PIMIS программд байршуулж, хяналт тавьж ажилласан | **90** |
| 3.13.1 | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээг хугацаанд нь чанартай зохион байгуулж гүйцэтгэлийн хяналт тавьж, эрх нээж ажиллана | Улсын төсөв 87.922.4 Орон нутгийн төсөв 3.615.0 | Гүйцэтгэлийн хувь | - | - | 100 | 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 51.527,8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 55 төсөл арга хэмжээ батлагдсанаас аймагт 25,383,2 сая төгрөгийн нийт 54 төсөл арга хэмжээ эрх шилжиж ирсэн бөгөөд жилийн эцсийн байдлаар 18,703,9 сая төгрөгийн санхүүжилтийг хянаж тайлагнаж ажиллалаа Санхүүжилтийн явцыг тухай | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төсвийн хөрөнгө оруулалтын PIMIS программд байршуулж, хяналт тавьж ажилласан | |
| **Зорилт 3.14** | **Шаардлагатай барилга байгууламж, төсөл арга хэмжээний ТЭЗҮ-г үе шаттайгаар боловсруулна** | Орон нутгийн төсөв 547.8 | Боловсруулагдсан зураг төслийн тоо | 0 | - | 20 | 2022 онд улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө, гадаадын зээл тусламжаар хэрэгжих 30-н төсөл арга хэмжээний зураг төслийг захиалан, хийж гүйцэтгүүлсэн бөгөөд үүнээс гадна төсөл арга хэмжээний ТЭЗҮ-г боловсруулахаар тусгайлан тавигдсан хөрөнгө оруулалтаар Эрдэнэмандал сум “Дэлхийн /Төв Ази/-ийн нүүдэлчдийн түүх, соёлын музей, аялал жуулчлалын цогцолборын хэсэгчилсэн төлөвлөгөө, “Багшийн хөгжил, судалгаа, арга зүйн төв”, “Жаргалант сумын төвийн үерийн хамгаалалтын барилга, байгууламж”, Өлзийт сумын ”Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Чулуут суманд баригдах “Сарлагийн музей, нүүдлийн соёл иргэншлийг судлах, олон улсын судалгааны төвийн барилга”, Чулуут сумын “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”, Өндөр-Улаан сумын “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Хотонт сумын “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”, “Тамир зусланг олон улсын хүүхдийн зуслан болгох зураг төсөл, хэсэгчилсэн төлөвлөлт”, Чулуут суманд баригдах “Халуун Ус багийн Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгын зураг төсөв, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө”, Эрдэнэбулган сумын 150 хүүхдийн III, ҮIII, IX дүгээр цэцэрлэгийн барилга зэрэг төсөл арга хэмжээний зураг төслийг захиалан гүйцэтгүүлж хүлээж аваад байна. | **100** |
| 3.14.1 | Шаардлагатай барилга байгууламж, төсөл арга хэмжээг тодорхойлж ТЭЗҮ-г боловсруулах ажлын даалгавар боловсруулан, захиалан гүйцэтгүүлэх | - | Боловсруулсан ажлын даалгаврын тоо | 0 | - | 20 | Хотонт сумын Хөөвөр багийн төв, Батцэнгэл сумын сумын Баян-Уул багийн төв, Хайрхан сумын сум Хайрхан багийн төвийн барилга. Халуун ус багийн сургууль цэцэрлэгийн цогцолбор, Өгийнуур, Жаргалант сумын ариун цэврийн байгууламж, Эрдэнэмандал сумын шинэ хуучин эмнэлгийг холбох хүзүүвчний барилга, Ихтамир сумын цагаан идээний | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөргүүрийн барилга, Чулуут сумын хог хаягдлын менежмент, Тариат сумын Соёлын төвийн засвар, Цэцэрлэг сумын ахуй ахуй үйлчилгээний барилгын засвар, Хотонт сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Ихтамир сумын хүүхдийн цэцэрлэгийн засвар, Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл дэд бүтэц, Булган сумын халуун усны завар, Эрдэнэбулган сум Худалдааны гудамжны инженерийн байгууламжийн засвар шинэчлэл, Эрдэнэбулган сум Хоршоолол баг 160 суудалтай бага сургуулийн барилга, Эрдэнэбулган сум 4-р сургуулийн 320 суудалтай сургуулийн өргөтгөл, Батцэнгэл, Жаргалант, Хотонт суманд баригдах 150 хүүхдийн цэцэрлэг, Ихтамир сумын цэцэрлэгийн барилгын өргөтгөл, Ихтамир сумын "Сумын хөгжил" ажил, Цэцэрлэг сумын сургуулийн уурын барилгын уурын зуух, шугамын засвар, Батцэнгэл сумын 320 суудалтай сургуулийн барилгын уурын зуухны засвар, Тариат сумын Тэрхийн цагаан нуурын хэсэгчилсэн төлөвлөгөө, Ахмадын өргөөний гадна пасадны засвар, Архивын өрөөний засвар, Хотонт сумын сургуулийн спорт заалны засвар, 6 дугаар багийн хогийн цэг цэгцлэх, ГБХЗХГ-ын засвар, 7 дугаар багт Ундны усны худаг гаргах, 2 дугаар багт Гэрэлт цамхаг суурьлуулах зэрэг улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2022 онд хийгдэх болон хийгдэж эхлэх төсөл арга хэмжээний зургийн даалгаврыг хянан, боловсруулан ажиллалаа. | |
| 3.14.2 | Боловсруулагдсан зураг төсвийг үндэслэн улс, орон нутгийн болон төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгуулах санал хүргүүлэх | - | Санал хүргүүлсэн эсэх | 0 | 1 | 1 | Аймгийн хэмжээнд улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих, төрийн суурь үйлчилгээний барилга байгууламжуудын шинээр барих, өргөтгөл, засварын ажлуудын саналыг сумдаас болон байгууллагуудаас авч нэгтгэн, эрэмбэлж батлагдсан зураг төслийг үндэслэн 2022 оны 05 дугаар сарын 01-ны | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дотор цахим системээр болон цаасан хэлбэрээр төсвийн ерөнхийлөн захирагчдад болон харьяа яамдуудад саналыг хүргүүлсэн. | |
| **Зорилт 3.15** | **Аймгийн төв болон сумдын Цэцэрлэгт хүрээлэн, гудамж талбай, орон сууцнуудын гадна фасад, зам талбайг тохижуулж хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, стандартуудыг хангуулан хүртээмжтэй орчны бий болгож, хотын өнгө үзэмжийг сайжруулна** | Хувийн хөрөнгө оруулалтаар | Тохижилтын ажлын тоо | 0 | 1 | 5 | Аймгийн төвийн иргэдийн аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд шаардлагатай нийтийн эзэмшлийн гудамж, талбай, зам дагуу байрлах гэрэлтүүлгийг аймгийн Хот тохижилт, үйлчилгээний газар хариуцан улиралд тохируулан асааж, график төлөвлөгөөний дагуу гэмтэл гарсан тухай бүрт засварлаж, асахгүй байгаа гэрэл, гэрлийн толгойг шинээр сольж ажиллаж байна.<br>Эрдэнэбулган сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 29-н гэрэлт цамхаг шинээр суурилуулан хүлээлгэн өгсөн бөгөөд 3,5,7 дугаар багуудад 2 км явган зам шинээр тавих ажил хийгдэж байна.<br>Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтцийн ажлын хүрээнд Эрдэнэбулган сумын Цэцэрлэгт хүрээлэн, гудамж талбай, орон сууцны барилгуудын гадна фасад, аймгийн төвийн гудамж талбай, өнгө үзэмжийг сайжруулах ажлыг эхний ээлжид хийхээр ажлын даалгаварт тусган боловсруулсан боловч улсын төсвийн тодотголоор 2022 онд тавигдсан 7.0 тэрбум төгрөг 840 сая төгрөг хүртэл танагдаад байгаа тул энэ оны хувьд тус ажлыг төлөвлөсөн түвшинд хийх боломжгүй болоод байна. 2022 онд тусгагдсан хөрөнгөөр тус төслийн зураг төсөл боловсруулах ажил хийгдэж байна.<br>2022 онд шинээр ашиглалтад орсон барилга байгууламжийн комисст Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоодын тэргүүн Г.Самбуудамзан оролцож Монгол улсын MNS 5682:2006 "Явган хүн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам", | **50** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | MNS 6055:2009 "Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин" зэрэг стандартуудын холбогдох үзүүлэлт шаардлагуудын хэрэгжилтэд, бодит нөхцөл байдал дээр нь очиж үнэлгээ хийж үүрэг даалгавар өгч ажиллалаа. | |
| 3.15.1 | Нийтийн орон сууцны дээвэр, гадна фасадыг шинэчлэх ажлыг эхлүүлнэ. | Улсын төсөв | Засвар хийгдсэн орон сууцны тоо | 0 | - | 10 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2024 онд Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтцийн ажлыг хэрэгжүүлэхэр 26.0 тэрбум төгрөг тавигдсан бөгөөд тус ажлын хүрээнд Эрдэнэбулган сумын 35 хуучин орон сууцны барилгуудын гадна фасад, аймгийн төвийн гудамж талбай, өнгө үзэмжийг сайжруулах ажлыг эхний ээлжид хийхээр ажлын даалгаварт тусган боловсруулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендерийг зарлан гүйцэтгэгчээр "Энигма констракшн" ХХК шалгаран зураг төслийн ажил хийгдэж байна. Гэвч улсын төсвийн тодотголоор 2022 онд тавигдсан 7.0 тэрбум төгрөг 840 сая төгрөг хүртэл танагдаад байгаа тул энэ оны хувьд тус ажлыг төлөвлөсөн түвшинд хийх боломжгүй болоод байна. 2022 онд тусгагдсан хөрөнгөөр тус төслийн зураг төсөл боловсруулах ажил хийгдэж байна.<br>2023 онд аймгийн 100 жил болохтой холбогдуулан дээрх ажлуудыг эхний ээлжид хийхээр гүйцэтгэгч компанитай зөвшилцөөд байна. | 50 |
| **Зорилт 3.16** | **Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтцийн ажлыг эхлүүлнэ** | Улсын төсөв 7.000.0 | гудамж талбайн тохижилтын ажлын тоогоор | 0 | - | 2 | Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтцийн ажлын ажлын даалгаврыг боловсруулан гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендерийг зарлан гүйцэтгэгчээр "Энигма констракшн" ХХК шалгаран зураг төслийн ажил хийгдэж байна. Гэвч улсын төсвийн тодотголоор 2022 онд тавигдсан 7.0 тэрбум төгрөг 840 сая төгрөг хүртэл танагдаад байгаа тул энэ оны хувьд тус ажлыг төлөвлөсөн түвшинд хийх боломжгүй болоод байна. | **50** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.16.1 | Цэцэрлэг хотын ундны усны эх үүсвэрийг шинэчлэн өргөтгөх. | Улсын төсөв | Гүйцэтгэлийн хувь | 0 | 20 | 100 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2024 онд Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтцийн ажлыг хэрэгжүүлэхэр 26.0 тэрбум төгрөг тавигдсан бөгөөд тус ажлын хүрээнд Цэцэрлэг хотын ундны усны эх үүсвэрийг шинэчлэн өргөтгөх ажлыг ажлын даалгаварт тусган боловсруулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендерийг зарлан гүйцэтгэгчээр “Энигма констракшн” ХХК шалгаран зураг төслийн ажил хийгдэж байна. Гэвч улсын төсвийн тодотголоор 2022 онд тавигдсан 7.0 тэрбум төгрөг 840 сая төгрөг хүртэл танагдаад байгаа тул энэ оны хувьд тус ажлыг төлөвлөсөн түвшинд хийх боломжгүй болоод байна. Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөг 2019 онд ус суваг ашиглалтын “Ар Ус Ундарга” ХХК боловсруулан батлуулсан бөгөөд 2022 онд төлөвлөгөөг шинэчлэн сайжруулаад байна. Аймгийн болон сумдын ус түгээх байрны 2021 онд хийгдсэн цэвэр усны шинжилгээг аймгийн Мэргэжлийн хяналтай хамтран гаргаж 2022оны 6-р сард Барилгын хөгжлийн төвд osnaah@gmail.com хаягаар хүргүүллээ. | 50 |
| 3.16.2 | Цэцэрлэг хотын гэр хорооллын айл өрхийг цэвэр, бохир усны шугам сүлжээнд үе шаттайгаар холбох ажлыг эхлүүлнэ | Улсын төсөв | Гүйцэтгэлийн хувь | 0 | 20 | 100 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2024 онд Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтцийн ажлыг хэрэгжүүлэхээр 26.0 тэрбум төгрөг тавигдсан бөгөөд тус ажлын хүрээнд Цэцэрлэг хотын гэр хорооллын айл өрхийг цэвэр, бохир усны шугам сүлжээнд үе шаттайгаар холбох ажлыг гүйцэтгэхээр ажлын даалгаварт тусган боловсруулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендерийг зарлан гүйцэтгэгчээр “Энигма констракшн” ХХК шалгаран зураг төслийн ажил хийгдэж байна. Гэвч улсын төсвийн тодотголоор 2022 онд тавигдсан 7.0 тэрбум төгрөг 840 сая төгрөг хүртэл танагдаад байгаа тул энэ оны хувьд тус ажлыг төлөвлөсөн түвшинд хийх боломжгүй болоод байна. Тус ажлын | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүрээнд Эрдэнэбулган сумын 1-р багийн 734 өрх, 2-р багийн 527 өрх, 3-р багийн 581 өрх, 4-р багийн 862 өрх, 5-р багийн 280 өрх, 7-р багийн 732 өрх цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбогдох боломжтой болно. | |
| **Зорилт 3.17** | **Төрийн суурь үйлчилгээний барилга байгууламжуудыг шинээр барьж, байгуулах, өргөтгөл, их засварын ажлыг шат дараатай хэрэгжүүлнэ** | - | Гүйцэтгэлийн дундаж хувь | 0 | 30 | 100 | 2022 онд Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Хотонт сумын Хөөвөр багийн төв, Батцэнгэл сумын сумын Баян-Уул багийн төв, Хайрхан сумын сум Хайрхан багийн төвийн барилга.Халуун ус багийн сургууль цэцэрлэгийн цогцолбор,Өгийнуур, Жаргалант сумын ариун цэврийн байгууламж, Эрдэнэмандал сумын шинэ хуучин эмнэлэгийг холбох хүзүүвчний барилга, Ихтамир сумын цагаан идээний хөргүүрийн барилга, Чулуут сумын хог хаягдлын менежмент, Тариат сумын Соёлын төвийн засвар, Цэцэрлэг сумын ахуй үйлчилгээний барилгын засвар, Ихтамир сумын хүүхдийн цэцэрлэгийн засвар,Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл дэд бүтэц, Булган сумын халуун усны завар, Эрдэнэбулган сум Худалдааны гудамжны инженерийн байгууламжийн засвар шинэчлэл, Эрдэнэбулган сум Хоршоолол баг 160 суудалтай бага сургуулийн барилга, Эрдэнэбулган сум 4-р сургуулийн 320 суудалтай сургуулийн өргөтгөл, Батцэнгэл, Жаргалант, Хотонт суманд баригдах 150 хүүхдийн цэцэрлэг, Ихтамир сумын цэцэрлэгийн барилгын өргөтгөл, Ихтамир сумын "Сумын хөгжил" ажил, Цэцэрлэг сумын сургуулийн уурын барилгын уурын зуух, шугамын засвар, Батцэнгэл сумын 320 суудалтай сургуулийн барилгын уурын зуухны засвар, Ахмадын өргөөний гадна пасадны засвар, Архивын өрөөний засвар, Хотонт сумын сургуулийн спорт заалны засвар, 6 дугаар багийн хогийн цэг цэгцлэх, ГБХЗХГ-ын засвар, 7 дугаар багт Ундны усны худаг гаргах, 2 дугаар багт Гэрэлт | **100** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | цамхаг суурьлуулах зэрэг төрийн суурь үйлчилгээний барилга байгууламжуудыг шинээр барьж, байгуулах, өргөтгөл, их засварын ажлуудыг хийж гүйцэтгэлээ. | |
| 3.17.1 | Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих, төрийн суурь үйлчилгээний барилга байгууламжуудыг шинээр барих, өргөтгөл, их засварын ажлуудын зураг төсвийг захиалан хийлгэх, батлагдсан зураг төслийн дагуу барилга угсралт, засварын ажилд гүйцэтгэлийн хяналт тавих | - | Гүйцэтгэлийн дундаж хувь | 0 | 30 | 100 | 2022 онд аймгийн хэмжээнд хэрэгжих улс, орон нутгийн болон төсөл хөтөлбөр, хувийн хөрөнгө оруулалтаар барилга угсралт, их засварын 71 төсөл арга хэмжээнд хяналт тавин ажилласан.<br>Улсын төсөв: 45<br>• Барилга угсралт – 33<br>• Их засвар - 12<br>ТЭЗҮ - 13<br>АОНХС-н хөрөнгөөр - 26<br>• Барилга угсралт – 11<br>• Их засвар – 15<br>Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтэс нийт 69 төсөл арга хэмжээнд байнгын ашиглалтад оруулсан.<br>Үүнээс:<br>• Хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 15 ТАХ-нд комисс ажилласан<br>• Улсын төсвийн 19 ТАХ-нд комисс ажилласан<br>• Төсөл хөтөлбөрөөр хэрэгжсэн 3 ТАХ-нд комис ажилласан<br><br>Орон нутгийн хөгжлийн сангаас 31 ТАХ-нд комисс ажилласан. | 100 |
| ДӨРӨВ. САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ТАЛААР | | | | | | | | |
| **АХЖТ-ний 3.1. Орон нутгийн төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг хангаж, үр ашгийг дээшлүүлж, төсвийн бие даах чадварыг нэмэгдүүлэх.** | | | | | | | | |
| **Зорилт 4.1** | **“Цахим санхүү” арга хэмжээ хэрэгжүүлэх** | - | | | | | Төсвийн бүх байгууллагуудыг төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн системд бүрэн хамруулан 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн цалингийн бүх гүйлгээг цахимаар хийж байна. Эрхийн бүртгэл, “ПОРТАЛ СИСТЕМ”-ийг бүрэн хэрэгжүүлж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс бүх төсөвт байгууллагуудын төлбөр тооцооны | **95** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | гүйлгээг цахимаар хийгдэх бэлтгэл ажил бүрэн хангагдсан болно. | |
| 4.1.1 | Цалингийн нэгдсэн системийг бүрэн нэвтрүүлнэ. | 20.0 | Цалингийн нэгдсэн системийг бүрэн нэвтрүүлсэн байгууллагын тоо | 90% | | 100% | Төсвийн бүх байгууллагуудыг төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн системд бүрэн хамруулан 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн цалингийн бүх гүйлгээг цахимаар хийж байна. | 100 |
| 4.1.2 | “Цахим санхүү” арга хэмжээг хэрэгжүүлэх сургалт зохион байгуулах, сайн туршлага судална | - | Зохион байгуулсан сургалт, оролцсон хүний тоо | 0 | | Санхүү, бүртгэлийн ажилтнуудын мэдлэг чадвар дээшилсэн байна. | Эрхийн бүртгэл, “ПОРТАЛ СИСТЕМ”-ийг бүрэн хэрэгжүүлж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс бүх төсөвт байгууллагуудын төлбөр тооцооны гүйлгээг цахимаар хийгдэх бэлтгэл ажил бүрэн хангагдсан болно. | 90 |
| **Зорилт 4.2** | **Татварын бүх төрлийн үйлчилгээг цахимжуулан иргэд, аж ахуйн нэгж байгууллагад жигд хүртээмжтэй хүргэж, татварын бааз суурийг нэмэгдүүлнэ** | Үйл ажиллагааны төсөв | Татварын үйлчилгээг нэмж цахимжуулсан тоо, татварын төлөгчийн нэмэгдсэн тоо | 70% | | 95% | Давхардсан тоогоор 9703 татвар төлөгчийн албан татвар, төлбөр хураамжийн тайланг цахимаар 100 хувь хүлээн авч, хөдөлгөөнт пос машинаар давхардсан тоогоор 14993 татвар төлөгчийн 704.4 сая төгрөг, QPAY-аар давхардсан тоогоор 103684 татвар төлөгч 16674.9 сая төгрөг, ибаримт апп-аар 1673 иргэн 29.1 сая төгрөгийн хөрөнгийн татварын орлогыг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүллээ.<br>Тайлант онд 22 иргэн, 34 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд ажлын зураг авалт хийж, 50.0-80.0 сая төгрөгийн борлуулалтын орлогыг нэмж тусгуулан, гэрээрээ оёдол, гэрийн мод, мод модон бүтээгдэхүүн, цагаан идээ хийж байгаа 28 татвар төлөгчөөс 1.5 сая төгрөгийн албан татварыг орон нутгийн төсөвт төвлөрүүллээ. Хөндлөнгийн мэдээллийг ашиглан 14 иргэнээс 91.3 сая төгрөгийн албан татварыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. | **100** |
| 4.2.1 | Татвар төлөгчийн бүртгэлийг төрийн болон бусад байгууллагын мэдээлэлд үндэслэн бүртгэнэ | Үйл ажиллагааны төсөв | Бүртгэлийн хувь | 70% | | 90% | Хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлсэн 152 татвар төлөгчийг татварын төрлийн бүртгэлд, бүртгэх байгууллагын мэдээг үндэслэн 32 татвар төлөгчийг үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын төрлөөр бүртгэж, цагдаагийн байгууллагын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бүртгэлийг үндэслэн 22 иргэнийг галт зэвсгийн албан татвар төлөгчөөр бүртгэж, автотээврийн газрын бүртгэлийг үндэслэн 1149 тээврийн хэрэгслийн ногдлыг шинэчлэн бүртгэсэн байна. | |
| 4.2.2 | Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлнэ | Үйл ажиллагааны төсөв | Төлөвлөгөөний биелэлтийн хувь | 100% | | 100% | Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт дүнгээр 110% ба татварын орлого 113%, татварын бус орлого 107%-ийн биелэлтэй байна. | 100 |
| **Зорилт 4.3** | **Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн хариуцлагыг сайжруулж, хэмнэлтийн горимыг баримтлан, төсвийн ил тод, шилэн байдлыг хангаж ажиллана** | Үйл ажиллагааны төсөв | Төсвийн болон Шилэн дансны хууль, Засгийн газрын 2020 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийн хувийг нэмэгдүүлсэн байна. | 92% | | 98% | Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн хариуцлагыг сайжруулж, хэмнэлтийн горимыг баримтлан, төсвийн ил тод, шилэн байдлыг хангаж ажилласан. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжилтийг хангуулах зорилгоор 4 ба 12 дугаар сард аймаг сумдын төсөв захиарагчид, санхүү, бүртгэлийн ажилтан, нягтлан бодогч нар хамрагдсан 2 удаагийн сургалт зохион давхардсан тоогоор 418 хүн хамрагдлаа. Мөн сумдад аймгийн удирдлагаас 2 удаа албан бичгээр чиглэл хүргүүлж биелэлтийг хангуулан ажиллалаа. | **100** |
| 4.3.1 | Аймгийн 2023 оны төсвийн төслийг боловсруулан хянуулж батлуулна | Үйл ажиллагааны төсөв | Төсвийн тухай хуульд нийцүүлэн хугацаанд нь боловсруулж, батлуулсан байна | 100% | | 2022 оны 12 сарын 05-ны өдрийн дотор дуусгасан байна | Аймгийн 2023 оны төсвийн төслийг боловсруулан 8 сард Сангийн яаманд хугацаанд нь хянуулсан. Аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан 2023 оны төсвийн төслийг бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган ажиллаж ИТХ-аар батлууллаа. | 100 |
| 4.3.2 | ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн тайланг хуулийн цаглабарт хугацаанд нэгтгэн гаргаж, аудит хийлгэнэ | Үйл ажиллагааны төсөв | Төсвийн тухай хуулийн цаглабарт хугацаанд хийгдсэн байна | 100% | | Төрийн байгууллагуудын санхүүжилтийг бүрэн олгож, ТЕЗ-ийн санхүүгийн тайланг 2022 оны 4 дүгээр сарын 25-ны дотор нэгтгэн | Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд төрийн аудитын газрын газрын 2022 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн 180 дугаар санал дүгнэлтээр зөрчилгүй дүгнэлт авсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гаргаж, аудит хийлгэн зөрчилгүй дүгнэлт авсан байна. | | |
| 4.3.3 | Төсвийн ил тод байдал, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж шилэн дансны мэдээлэл байршуулалт, тайлан илгээлтийн хувийг нэмэгдүүлнэ | Үйл ажиллага аны төсөв | Мэдээлэл байршуулалтын хувь | 96% | | 97% | Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа 142 байгууллагын шилэн дансны мэдээлэл байршуулалт 97 хувьтай байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дотоод аудитын дүнгээр аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээ байршуулалт тогтмолжсон, нийт 142 байгууллагаас 139 байгууллага илгээж, хэрэгжилт 97,9 хувьтай байна. | 100 |
| **Зорилт 4.4** | **Орон нутагт хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний худалдан авалтад дотоодын аж ахуй нэгж үйлдвэрлэл эрхлэгчдийг тэргүүн ээлжид дэмжих бодлогыг баримтлан, худалдан авах ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, иргэд, төрийн бус байгууллагын хяналтын дор ил, тод нээлттэй зохион байгуулна** | Үйл ажиллага аны төсөв | Орон нутгийн аж ахуй нэгж, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжсэн тоо, бүрэн цахимд шилжсэн байна | Давхардс ан тоогоор 13 аж ахуйн нэгж хатрагда ж, худалдан авах ажиллага аг 100% цахимаар зохион байгуулс ан | | Аж ахуйн нэгжийн тоог 15-д хүргэж, худалдан авах ажиллагаа г 100% цахимаар зохион байгуулна. | Төсвийн ерөнхийлөн захирагч болон харъяа байгууллагууд улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр нийт 134.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 169 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас 17787.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 24 төсөл арга хэмжээг орон нутгийн 14 аж ахуйн нэгж, сумдад 619.6 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээний тендерт орон нутгийн 4 компани тус тус шалгарч гэрээ байгуулж 106 төсөл арга хэмжээний худалдан авалтыг 100% цахим хэлбэрээр зохион байгуулсан. | **90** |
| 4.4.1 | Орон нутгийн хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний худалдан авалтад дотоодын аж ахуй нэгж үйлдвэрлэл эрхлэгчдийг тэргүүн ээлжид дэмжих бодлогыг баримтлана. | Үйл ажиллага аны төсөв | Нэмэгдсэн аж ахуйн нэгж, үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо | Давхардс ан тоогоор 13 аж ахуйн нэгж | | Аж ахуйн нэгжийн тоог 15-д хүргэнэ | Төсвийн ерөнхийлөн захирагч болон харъяа байгууллагууд улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр нийт 134.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 169 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас ОНӨГ-т зарласан 17787.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 24 төсөл арга хэмжээг орон | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нутгийн 14 аж ахуйн нэгж, сумдад 619.6 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээний тендерт орон нутгийн 4 компани тус тус шалгарч гэрээ байгуулсан байна. | |
| 4.4.2 | Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, иргэд, төрийн бус байгууллагын хяналтын дор ил, тод нээлттэй зохион байгуулна | Үйл ажиллага аны төсөв | Цахимаар зохион байгуулсан худалдан авах ажиллагааны хувь | 100% | | 100% | Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяаны төсөвт албан байгууллага, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын 2022 онд хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хянан баталгаажуулж, Сангийн яамаар батлуулан, төрийн худалдан авах ажиллагааны цахим систем tender.gov.mn сайтад нийтлүүлсэн. 2022 онд улсын болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт 134032.3 сая төгрөгийн өртөг бүхий 169 төсөл арга хэмжээний худалдан авалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан байна. Үүнээс: Орон нутгийн өмчийн газар нь улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 126487.8 сая төгрөгийн өртөг бүхий 63 төсөл арга хэмжээг, төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа байгууллагууд 7544.5 сая төгрөгийн өртөг бүхий 106 төсөл арга хэмжээний худалдан авалтыг 100% цахим хэлбэрээр зохион байгуулсан. | 100 |
| ТАВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ТАЛААР | | | | | | | | |
| ЭРҮҮЛ МЭНД | | | | | | | | |
| АХЖТ-ний 1.1. Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| **Зорилт 5.1** | **Коронавируст халдвар Ковид 19 цар тахлын үеийн хариу арга хэмжээг авна.** | - | Хувиар тооцно | I-тун - 85,7%<br>II-тун - 80,5%<br>III-тун - 26,5% | I -тун - 84,3%<br>II-тун - 80.5%<br>III-тун - 25.3% | I-тун - 85,7%<br>II-тун -82%<br>III-тун - 50% | Аймгийн хэмжээнд нийт 19025 сурагчдын 65% нь хамрагдсан. 2022 оны 11-р сарын 15-ны өдрийн байдлаар вакцины 1 дүгээр тунд 60891 хүн буюу 86,4%,2-р тунд 57627 хүн буюу 81.7%,3-р тунд 27334 хүн буюу 38.8 %,4-р тунд 2516 хүн буюу 3.6% хамруулсан. | **80** |
| 5.1.1 | Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг улирлын томуугийн вакцинд хамруулах | - | Тоогоор тооцно | СӨБ-20%<br>ЕБС-20% | 0% | СӨБ-20%<br>ЕБС-20% | Архангай аймгийн эрүүл мэндийн газар, өрхийн эрүүл мэндийн төвийн хамтран сурагчдыг улирлын томуугийн вакцинд хамруулах ажлыг намрын улиралд зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд нийт 19025 | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сурагчдын 65% нь хамрагдсан. Коронавирусын вакциныг ахлах ангийн сурагчдын 89% хамруулсан халдварын тоо буурч байгаатай холбоотой ахлах ангийн сурагчдын хамрагдалт буурсан үзүүлэлттэй байна. 11 дүгээр сарын байдлаар улирлын томуугийн вакцинд 1-5 насны 4776 хүүхэд хамрагдаад байна. | |
| 5.1.2 | Хүн амыг коронавирусийн эсрэг вакцинд хамруулах | - | Хувиар тооцно | I-тун - 85,7%<br>II-тун - 80,5%<br>III-тун - 26,5% | I -тун - 84,3%<br>II-тун - 80.5%<br>III-тун - 25.3% | I-тун - 85,7%<br>II-тун -82%<br>III-тун - 50% | Коронавирусийн эсрэг вакцинжуулалтын үйл ажиллагааг 2021 оны 4 дүгээр сараас эхлэн 22 байнгын цэг дээр вакцинжуулалтыг тасралтгүй зохион байгуулж байна. 2022 оны 11-р сарын 15-ны өдрийн байдлаар вакцины 1 дүгээр тунд 60891 хүн буюу 86,4%,2-р тунд 57627 хүн буюу 81.7%,3-р тунд 27334 хүн буюу 38.8 %,4-р тунд 2516 хүн буюу 3.6% хамруулсан. | 90 |
| 5.1.3 | Коронавирусийн халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулах | - | Иргэдэд сурталчилгааг хүргэсэн аргачлалаар тооцно | -Постер /сурталчилгаа /-313<br>-Телевизэд ярилцлага -8<br>-Сонин-5 | -Постер /сурталчилгаа /-123<br>-Телевизэд ярилцлага -2<br>-Сонин-2 | -Постер /сурталчилгаа /-232<br>-Телевизэд ярилцлага -1<br>-Сонин-3 | Коронавируст халдвар (ковид 19)-ийн үед эмнэлгийн тусламж үзүүлэх уушги судлалын эмч 1, ариутгагч 5, эрчимт эмчилгээний эмч 2, сувилагч 2 нарыг мэргэшүүлэн бэлтгэсэн. ЭМЯ, ЭМХТ, ЭМГ-аас КОВИД-19 коронавирусийн халдварын үед үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний талаар гарсан дүрэм журам заавраар нийт 39 удаагийн сургалтыг зохион байгуулан давхардсан тоогоор 2526 хүнийг хамруулсан. | 90 |
| **Зорилт 5.2** | **Цахим эрүүл мэнд арга хэмжээ хэрэгжүүлэх** | 200.0 | Арга хэмжээний хэрэгжилтийн хувиар | Шинээр тооцно | Арга хэмжээний хэрэгжилтийг 30 хувьд хүргэнэ. | Арга хэмжээний хэрэгжилтийг 70 хувьд хүргэнэ | Цахим эрүүл мэнд арга хэмжээний хүрээнд орон нутгийн хөгжлийн сангаас 200.0 сая төгрөг төсөвлөж E-mongolia-д нийт эрүүл мэндийн 8 үйлчилгээ нэвтрээд байна. Үүнд Эрүүл мэндийн Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, Нэгдсэн эмнэлгийн цаг товлох, эмнэлгийн магадалгаа гэх мэт | **70** |
| 5.2.1 | Цахим эрүүл мэнд арга хэмжээ хэрэгжүүлэх | | Арга хэмжээний хэрэгжилтийн хувиар | Шинээр тооцно | Арга хэмжээний хэрэгжилтийг 30 хувьд хүргэнэ | Арга хэмжээний хэрэгжилтийг 70 хувьд хүргэнэ | Цахим эрүүл мэнд арга хэмжээний хүрээнд орон нутгийн хөгжлийн сангаас 200.0 сая төгрөг төсөвлөгдөж Сумын эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгийн удирдлагуудтай санал солилцох 2 удаагийн уулзалт зохион байгуулагдаж тухайн эрүүл мэндийн төвүүд | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өөрсдийн салбарын хүрээнд ашиглаж буй програмыг ICT-группээс санал болгосон програмыг ижил үүрэг гүйцэтгэх тул нэвтрүүлэхээс татгалзаж E-Kiosik-г суурилуулах дээр санал зөвшилцсөн. Уг ажил санхүүжилтийн түвшинд шийдэгдээгүй байна.<br>E-mongolia-аас Архангай аймагт ажиллаж Эрүүл мэндийн Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл , Нэгдсэн эмнэлгийн цаг товлох, эмнэлгийн магадалгаа 3 арга хэмжээг E-Mongolia порталд нэвтрүүлсэн. | |
| **Зорилт 5.3** | **Хавдрын эрт илрүүлгийн төвд тоног төхөөрөмж нийлүүлнэ** | 350.0 | - | - | Холбогдох техникийн тодорхойлолт боловсруулж ОНӨГ-т хүргүүлсэн байна. | Машинтай болсон байна. | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хавдрын эрт илрүүлгийн төвд явуулын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх зориулалтаар ашиглах автомашины<br>Улсын төсөвт 350.0 сая төгрөг тусгагдсан болович 80.0 саяг төгрөг батлагдсан. Гүйцэтгэгч кампанийн зүгээс 2022 онд ЭХО болон бусад хэрэгслийг нийлүүлж, 2023 онд санхүүжилтийг бүрэн шийдвэрлэгдээр машиныг хүлээлгэн өгөхөөр гэрээг захилагч талтай байгуулж 2022 оны 11 дүгээр сард Нэгдсэн эмнэлэгт иж бүрэн тоноглогдсон эрт илрүүлгийн үзлэгийн явуулын машин нийлүүлэгдсэн. | **100** |
| 5.3.1 | Хавдрын эрт илрүүлгийн үзлэгийн явуулын машинаар хангах | 350.0 | - | - | Холбогдох техникийн тодорхойлолт боловсруулж ОНӨГ-т хүргүүлсэн байна. | Машинтай болсон байна | 2022 оны Улсын төсөвт 350.0 сая төгрөг тусгагдсан болович 80.0 сая төгрөг батлагдсан. Гүйцэтгэгч кампанийн зүгээс 2022 онд ЭХО болон бусад хэрэгслийг нийлүүлж, 2023 онд санхүүжилтийг бүрэн шийдвэрлэгдэхээр машиныг хүлээлгэн өгөхөөр захилагч талтай гэрээ байгуулж 2022 оны 11 дүгээр сард Нэгдсэн эмнэлэгт иж бүрэн тоноглогдсон эрт илрүүлгийн үзлэгийн явуулын машин нийлүүлэгдсэн. | 100 |
| **Зорилт 5.4** | **Эмнэлэг, эм хангах нийлүүлэх, эмийн сангуудын стандартын хэрэгжилтийг хангуулж хүртээмжийг нэмэгдүүлнэ** | | Хяналтад хамрагдсан Эмнэлэг Эм ханган нийлүүлэх Эмийн сан | Хяналтад хамрагдсан Эмнэлэг –6 | Стандартын хэрэгжилт хангагдсан байна | Стандартын хэрэгжилт хангагдсан байна | Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрх тусгай зөвшөөрөл олгосон 9 гэрчилгээний хугацааг сунгасан 31, түдгэлзүүлсэн 1, сэргээсэн 1, үйл ажиллагааны чиглэл нэмсэн 1 байна. | **100** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Ариутгал халдваргүйжүүлэлтийн тоо | Эм ханган нийлүүлэх 1 Эмийн сан -8 Ариутгал халдваргүйжүүлэлт -2 | | | | |
| 5.4.1 | Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх сэргээх | - | Салбар комиссын хурлын тоо Олгосон тусгай зөвшөөрлийн тоо, Сунгасан тусгай зөвшөөрлийн тоо Түдгэлзүүлсэн тусгай зөвшөөрлийн тоо Сэргээсэн тусгай зөвшөөрлийн тоо | Салбар комиссын хурлын тоо 3 Олгосон тусгай зөвшөөрлийн тоо 4 Сунгасан тусгай зөвшөөрлийн тоо -16 Түдгэлзүүлсэн тусгай зөвшөөрлийн тоо-1 Сэргээсэн тусгай зөвшөөрлийн тоо-1 | Байгууллагуудын ирсэн материалыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна | Байгууллагуудын ирсэн материалыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна | Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 4 удаагийн хурлаар 31 байгууллагын Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хугацааг сунгасан. Үүнээс сумын Эрүүл мэндийн төв 3, Хувийн эмнэлэг 7, сувилал 1, Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх 1, Эмийн сан 18, байна. Нийт 9 байгууллагад Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрх тусгай зөвшөөрөл олгосон байна.<br>Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэж буй 1 эмийн сангийн зөвшөөрлийг түдгэлзүүлсэн. Хяналтаар ирүүлсэн зөрчлийг арилгасны дагуу тус зөвшөөрлийг сэргээсэн. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэж буй ариутгалын үйлчилгээ эрхлэж буй байгууллагад ариутгалын бодис худалдах чиглэл нэмэхийг зөвшөөрсөн. | 100 |
| БОЛОВСРОЛ | | | | | | | | |
| АХЖТ-ний 2.3. Хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлнэ. | | | | | | | | |
| **Зорилт 5.5** | **“Цахим боловсрол” арга хэмжээ хэрэгжүүлэх** | 190.0 | Арга хэмжээний хэрэгжилтийн хувиар | Боловсролын удирдлаг | Арга хэмжээний хэрэгжилти | Арга хэмжээний хэрэгжилти | Цахим Архангай арга хэмжээг хэрэгжүүлэх ажил 12 дугаар сард дууссан. | **63,3** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | а мэдээллийн нэгдсэн системийг аймгийн хэмжээнд нэвтрүүлсэн. Лаборатори I сургуульд "MOODLE" системийг нэвтрүүлэн ажиллаж байна. Шинээр тооцно | йг 40 хувьд хүргэнэ. | йг 70 хувьд хүргэнэ | | |
| 5.5.1 | SMART танхим байгуулах | | Танхимын тоо | 0 | - | 25 | Ерөнхий боловсролын 25 сургуульд СМАРТ танхим байгуулахад шаардлагатай 25 ухаалаг самбарыг улсын төсвийн 200.0 сая төгрөгийн санхүүжилтээр шийдвэрлэлээ. | 70 |
| 5.5.2 | ЕБС-иудад MOODLE систем нэвтрүүлэх | 132.8 | Систем нэвтрүүлсэн сургуулийн тоо | Лаборатори I сургуульд "MOODLE" системийг нэвтрүүлэн ажиллаж байна | 10 | 27 | БШУГ болон Лабротори 1 дүгээр сургууль дээр БШУЯ-ны санхүүжилтээр мульти медиа студийг нээснээр багш, мэргэжилтнүүдэд цахим контент бэлтгэх нөхцөл бүрдлээ. 2021-2022 оны хичээлийн жилд аймгийн сургууль,цэцэрлэгийн багш нар нийтдээ 464 цахим контентийг бэлтгэн сургалтандаа ашигласан. МСҮТ-үүд нь Багш нарын цахим хичээлийн арга зүйг сайжруулах үүднээс "Хамтын хичээл" "Цахим хичээлийн уралдаан" -ны зарлаж үр дүнг тооцон ажилласан байна. Энэ удаад 700 гаруй цахим хичээл 210 гарын авлага, 1027 хэвлэмэл материалыг сургалтанд нэвтрүүлж үр дүнг тооцжээ. | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.5.3 | “Хүүхэд бүрт тэгш боломж-ЭЕШ 2022” төсөл хэрэгжүүлэх | | -хамрагдсан хүүхдийн тоо -ЭЕШ-ын дундаж | -1200 хүүхэд, -ЭЕШ-ын дундаж 521.0 | 864 хүүхэд шалгалтад бэлтгэнэ. | -864 хүүхэд, -ЭЕШ-ын дунджийг өмнөх оноос ахиулсан байна | Их дээд сургуульд элсэгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноог нэмэгдүүлэхэд чиглэсэн “Хүүхэд бүрт тэгш боломж-ЭЕШ 2022” төслийг GOODSCHOOL, Сайн сургуулийг таны дэргэд ТББ-тай хамтран ерөнхий боловсролын сургуулиудын 12 дугаар ангийг төгсөгч, математик, англи хэл, нийгмийн ухаан, физик, хими, биологийн хичээлээр элсэлтийн ерөнхий шалгалт өгөх 864 сурагчдыг хамруулан 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс 05 дугаар сарын 27-ны өдөр хүртэл хэрэгжүүлж, орон нутгийн төсвөөс 117.0 сая төгрөгийг зарцуулж байна. Энэ ажлын хүрээнд сумдын Засаг дарга нар, ЕБС-ийн захирлуудад тус тус албан бичгээр ажлын чиглэл хүргүүлэн ажиллалаа. Аймгийн ЗДТГ, төсөл хэрэгжүүлэгч байгууллагын хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулан батлуулж, гүйцэтгэлд хяналт тавин, гэрээний дагуу санхүүжилтийг хийх захирамжийн төслийг боловсруулан шийдвэрлүүллээ. Энэхүү 6 хичээлээс Фикик, Хими, Биологийн хичээлийн дундаж өмнөх оноос өсч, математик, Нийгмийн тухай мэдлэг, Англий хэлний хичээлийн дундаж буурсан байна. | 70 |
| 5.5.4 | 2. Цэцэрлэг, сургууль, дотуур байрыг шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах | “Эрдэнэт” үйлдвэрийн санхүүжилт | Ажлын гүйцэтгэлийн хувь | 15% (Хайрхан, Хангай, Цэцэрлэг сумдын сургууль цэцэрлэг, дотуур байрыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай | 50% | 100% (Хангай, Хайрхан, Цэцэрлэг, Өндөр-Улаан, Чулуут, Хотонт, Хашаат, Батцэнгэл сумдын сургууль, цэцэрлэг, дотуур байрын | Хайрхан, Хангай, Цэцэрлэг сумын сургуулийн хичээлийн болон дотуур байр, хүүхдийн цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийн ажил дуусаж улсын комисст хүлээлгэн өгсөн. Батцэнгэл, Өндөр-Улаан, Чулуут сумын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн АЦБ-ийн ажлын гүйцэтгэл 85%-тай хийгдэж байна. 12 сард багтаж ашиглалтад орно.<br>Хашаат, Хотонт сумдын сургууль, цэцэрлэгийн АЦБ-ийг сайжруулах ажил 3-р ээлжинд хийгдэхээр хүлээгдэж байна. | 85 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | болгох ажил эхэлж зураг төсөв бэлэн болсон.) | | ариун цэврийн байгууламжийг сайжруулсан байна. ) | | |
| СОЁЛ, УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР | | | | | | | | |
| **Зорилт 5.6** | **Нийтийн номын сан, сумдын соёлын төвийн номын санг нэгдсэн сүлжээнд холбож, цахим номын сангийн үйл ажилллагааг эхлүүлэх** | 7.0 | Ажлын гүйцэтгэлийн хувь | Шинээр тооцно | | 100 | Нийтийн номын сан, сумдын соёлын төвийн номын санг нэгдсэн сүлжээнд холбох ажлыг Цахим Архангай арга хэмжээний хүрээнд шийдвэрлэх тухай аймгийн Засаг даргын зөвлөлийн шийдвэр гарсан. | **80** |
| 5.6.1 | Нийтийн номын сан, сумдын соёлын төвийн номын санг нэгдсэн сүлжээнд холбох | - | Серверээр хангасан эсэх /тийм-1, үгүй-0/ | 0 /Номын сангууд нэгдсэн сүлжээнд холбогдоогүй/ | Судалгаа, тоцоог гаргасан байна. | 1 /Өндөр хүчин чадал бүхий серверээр хангаж, нэгдсэн сүлжээнд холбосон байна/ | Орон нутгийн төсвийн 7.0 сая төгрөгийн санхүүжилтээр Нийтийн номын сан, сумдын соёлын төвийн номын санг нэгдсэн сүлжээнд холбох серверээр холбох ажлыг аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасны дагуу зардлын захирамжийн төсөл бичиж аймгийн Засаг даргын зөвлөлд оруулллаа. Зөвлөлөөс “Цахим Архангай” арга хэмжээний хүрээнд шийдвэрлэх боломжийг судалж үзсэний дараа шийдвэрлэхээр хойшлууллаа. | 70 |
| 5.6.2 | Цахим номын сангийн үйл ажиллагааг эхлүүлэх | - | -Цахим каталогит оруулсан номын эзлэх хувь<br>-Номын фондод цахим номын эзлэх хувь | -аймгийн номын сан болон сумын номын сангийн фондын 75%-ийг цахим каталогит оруулсан<br>-цахим номын эзлэх хувь-0.1 | -цахим каталогийн эзлэх хувь-90, цахим номын эзлэх хувь 0,15 | -цахим каталогийн эзлэх хувь-100<br>-цахим номын эзлэх хувь-0.2 | Номын сангийн нийт сан хөмрөгийг 100 хувь электрон каталогит оруулсан. Цахим сан хөмрөг үүсгэх ажил хийгдэж, цахим сан хөмрөгийн эзлэх хувь 0.18-д хүрсэн. | 90 |
| ХҮН АМЫН ХӨГЖИЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАМГААЛАЛЫН ТАЛААР | | | | | | | | |

| АХЖТ-ний 2.4. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, нийгмийн хамгааллын үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэж, амьдралын чанарыг дээшлүүлэн, гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 5.7** | **“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв”-ийн барилгыг ашиглалтад оруулах** | Олон улсын төсөл | Төлөвлөлтийн гүйцэтгэлийн хувь | 38 | 40-65 | 100 | 2022 онд барилгын карказ, уурын зуухны ажил хийгдээд байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийн төвийн барилгын үйл ажиллагаатай холбоотой барилгын ажлыг эрчимжүүлэх албан бичгийг гүйцэтгэгч тал, барилгын үйл ажиллагаа удааширч байгаа талаарх хүсэлтийг захиалагч талд хүргүүлсэн. | **70** |
| 5.7.1 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн хүний нөөцийг ХНХЯ-ны төслийн нэгжтэй хамтран сургаж бэлтгэх | Олон улсын төсөл | Чадавхижуулах сургалтад хамрагдсан хүний тоо | 10 | 10-15 | 15-20 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулсан нийгмийн сэргээн засах үндэсний сургагч багш бэлтгэх сургалтад 3 хүн, нийгмийн ажил ба хөгжлийн бэрхшээл сургалтад 5 хүн, хэл засалч бэлтгэх сертифекаттай сургалтад 7 хүн, хүүхдийн хөдөлгөөн засал, хөдөлмөр заслын сургалтад 10 хүн, нийт 25 хүнийг чадахжуулах сургалтад хамруулсан байна. | 70 |
| **Зорилт 5.8** | **Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлөөр 2022 онд хэрэгжих төсөл хөтөлбөрүүдийг батлуулах, хэрэгжүүлэх** | ХЭДС | Хөтөлбөрийн тоо | 5 | 7 | 7 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр аймагт хэрэгжих 6 хөтөлбөр 28 арга хэмжээний төсвийн хуваарийг аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлэн баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | **100** |
| 5.8.1 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт тавих, ажлын байр бий болгох | ХЭДС | Шинэ ажлын байрны тоо | 1148 | 450 | 1200 | Улсын төсөв, орон нутгийн төсөв, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, Засгийн газрын тусгай сангууд болон хувийн аж ахуйн нэгж, байгуулага болон бусад хөтөлбөр төслийн хүрээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар 706 шинэ ажлын байр бий болсон байна. | 100 |
| **Зорилт 5.9** | **Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Залуучуудын хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах** | Хүүхэд хамгааллын зардал | Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн тоо | - | 3 төлөвлөгөө батлагдсан байх | Батлагдсан баримт бичгийн хэрэгжилтэр | Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Залуучуудын хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, тус зөвлөлүүдийн хурлыг зохион байгуулан төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | **100** |
| 5.9.1 | Залуучуудын хөгжил, оролцоог дэмжих | Хүүхэд хамгаалл | Үйлчилгээнд хамрагдсан | 31 | 15 | 35 | Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийн хүрээнд 35 залууд ажил хөдөлмөр | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | ын зардал | залуучуудын хувь | | | | эрхлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулж 14 хоногийн сургалт дадлага хийх ажил олгогч байгууллагатай нь холбон зуучлах, ажлын байранд дадлагажин ажлын гараагаа эхлэхэд нь туслан чиглүүлэн ажиллаж байна. | |
| 5.9.2 | Хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих үйл ажиллагааны чанарыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Хүүхэд хамгаалл ын зардал | Хүүхдийн хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн хувь | 31 | 15 | 45 | “Архангайн хүүхдүүд” хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөр нь 2022-2024 онд хэрэгжих бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар 19 сумдтай хамтран хүүхдийн үндэсний болон орон нутгийн чуулган, тэмдэглэлт баярын арга хэмжээ, хүүхдийн оролцооны байгууллагын тэмцээн уралдаан, зуслангийн хүүхэд, хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ, хүүхдийн нэвтрүүлгийн редакци, зөвлөгөөн, сургалт, хөгжлийн 12 төрлийн арга хэмжээг зохион байгуулж 12300 гаруй хүүхдийг хамруулж ажилласан. Мөн хүүхдийг болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг сурталчилан таниулах, хүүхдийн хүмүүжил төлөвшилд эцэг эх, багшийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор “Хүүхдийн асуудлаар үүрэг хүлээгчдийн аймгийн чуулган”, МУЗГ-ын 2019 оны 57 дугаар тогтоолын дагуу аймгийн нутаг дэвсгэрт өвөл, хаврын улиралд хурдан морины уралдаан зохион байгуулахыг хориглох тухай Засаг даргын захирамж гарган хэрэгжилтийг ханган ажилласан. Мөн уралдаанч хүүхдийн эрхийг хамгаалах, уяачийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор “Уралдаанч хүүхдийн эрх ба уяачийн хариуцлага” аймгийн зөвлөгөөнийг 19 сумын уяачидыг оролцуулан зохион байгуулсан байна. | 100 |
| **Зорилт 5.10** | **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын ажлыг** | - | Комиссын хурлын тоо | 17 | 8 | 18-20 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбар комисс нь 2022 оны эхний хагас жилийн байдлаар 8 удаа хуралдаж 208 хүүхэд хурлаар орж | **100** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **удирдлага, зохион байгуулалтаар хангах** | | | | | | мэргэжлийн эмчийн үзлэгт хамрагдаж, зөвлөгөө авсан. Комиссын гишүүд нарийн мэргэжлийн эмч нарыг Хөвсгөл аймагт зохион байгуулсан бүсийн чадавхижуулах сургалтад хамруулсан. | |
| 5.10.1 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссоор асрагаанд хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тогтоох | - | -Хуралдаан болон оролцогчдын тоо<br>-Асрагаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо | 17 удаагийн хурал 250 хүүхэд | 120-140 хүүхэд | 18-20 удаа хуралдах<br>220-230 хүүхэд | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбар комиссын хуралд нийт 208 хүүхэд орсноос 175 хүүхдийн байнгын асрагааг сунгаж, 33 хүүхдийн асрагааг онош тодруулахаар буцаасан байна. Комиссын үйл ажиллагааг явуулахад шаардагдах 3.0 сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувийн хэрэг, асрагааны маягт, бүртгэлийн журнал зэргийг хэвлүүлсэн. | 100 |
| ЗУРГАА. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛААР | | | | | | | | |
| **Зорилт 6.1** | **Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүн үр нөлөөг дээшлүүлнэ.** | - | -Журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөмж хүргүүлсэн байх Тийм-1, Үгүй-0 | 1 | 1 | 1 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэлтэс, агентлагт хагас, бүтэн жилээр дүгнэлт зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>2022 оны 01 дүгээр сард хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, сард дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлсэн. | **97,5** |
| 6.1.1 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж боловсруулах, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх | - | -Хяналт-шинжилгээ, үнэлгээний тоо<br>-Зөвлөмжийн тоо | 2<br>2 | 1<br>1 | 2<br>2 | Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний unelgee.gov.mn мэдээллийн санд байршуулсан ТЗУХ-ээс нэгтгэж ирүүлсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2021 оны жилийн эцэс, 2022 оны эхний хагас жилийн байдлаар журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг тус тус хийж хяналт- | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шинжилгээ, үнэлгээний дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн V хуралдаан, хэлтсийн дарга нарын 2022 оны 07 дугаар сарын 08-ны III хуралдаанд тус тус танилцуулан хэлэлцүүлж, 2022 оны 02 дугаар сарын 15-ны ны өдрийн 03/264, 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 03/1230 дугаар албан бичгүүдээр хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлсэн. 2021 оны жилийн эцсийн байдлаар 163 шийдвэрийн 282 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 197 заалт “бүрэн хэрэгжсэн” буюу 100 хувь, 62 заалт “хэрэгжих шатанд” буюу 70 хувь, 7 заалт “хэрэгжилт хангалтгүй” буюу 30 хувь, 16 заалтын хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй, нийт заалтын хэрэгжилтийн дундаж 91.1 хувь, 2022 оны эхний хагас жилийн байдлаар 78 шийдвэрийн 182 заалтын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 56 заалт “бүрэн хэрэгжсэн” буюу 100 хувь, 67 заалт “хэрэгжих шатанд” буюу 70 хувь, 25 заалт “хэрэгжилт хангалтгүй” буюу 30 хувь, хэрэгжээгүй 1 заалт, 33 заалтын хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй, нийт 282 заалтын биелэлтийн дундаж 74.0 хувь байв. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний дүнд үндэслэн тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө боловсруулж ажиллах, тайлан мэдээний чанарыг сайжруулах талаар зөвлөмж боловсруулан 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 03/471, 07 дугаар сарын 22-ны өдрийн 03/1266 албан бичгүүдээр аймгийн ЗДТГ-ын 5 хэлтэс, 28 агентлагт хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Зөвлөмжийн биелэлтийг 2022 оны жилийн эцсийн байдлаар агентлагийн жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд дүгнэнэ. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6.1.2 | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж боловсруулах, тайланг unelgee.gov.mn мэдээллийн санд байршуулж баталгаажуулах, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх | - | -Хяналт-шинжилгээ, үнэлгээний тоо<br>-Зөвлөмжийн тоо | 2<br>2 | 1<br>1 | 2<br>2 | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний unelgee.gov.mn мэдээллийн санд байршуулсан 16 зорилт 18 арга хэмжээн дээр аймаг хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан 56 зорилт 135 арга хэмжээг нэмж хяналтад аван, нийт 72 зорилт 153 арга хэмжээний хэрэгжилтэд 2021 оны жилийн эцэс, 2022 оны эхний хагас жилийн байдлаар журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг тус тус хийж хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн IV хуралдаан, хэлтсийн дарга нарын 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн I хуралдаанд тус тус танилцуулан хэлэлцүүлж, 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 03/95 , 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 03/1182 дугаар албан бичгүүдээр хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлсэн. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 56 зорилтын 153 арга хэмжээний хэрэгжилтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд, “үр дүнтэй” буюу 100 хувьтай арга хэмжээ 29, гол үр дүн нь гарч эхэлж байгаа буюу 90 хувьтай арга хэмжээ 41, гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70 хувьтай арга хэмжээ 36, бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн буюу 50 хувьтай арга хэмжээ 11, бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа буюу 30 хувьтай арга хэмжээ 27, хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй “0” хувьтай арга хэмжээ 10, нийт 153 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 68.4 хувь, 2022 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд, “үр дүнтэй” | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | буюу 100 хувьтай арга хэмжээ 21, гол үр дүн нь гарч эхэлж байгаа буюу 90 хувьтай арга хэмжээ 42, гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70 хувьтай арга хэмжээ 47, бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн буюу 50 хувьтай арга хэмжээ 14, бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа буюу 30 хувьтай арга хэмжээ 23, хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй “0” хувьтай арга хэмжээ 6, нийт 153 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 69.0 хувь байсан. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах, тайлан мэдээний чанарыг сайжруулах талаар зөвлөмж боловсруулан 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 03/471, 07 дугаар сарын 22-ны өдрийн 03/1266 албан бичгүүдээр аймгийн ЗДТГ-ын 5 хэлтэс, 28 агентлагт хүргүүлсэн, зөвлөмжийн биелэлтийг 2022 оны жилийн эцсийн байдлаар агентлагийн жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд дүгнэнэ. | |
| 6.1.3 | Засгийн газрын гишүүн аймгийн Засаг даргатай 2021 онд байгуулсан гэрээний үүргийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж боловсруулах, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх | - | -Журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хэлтэс, агентлагуудад зөвлөмж хүргүүлсэн эсэх<br>1 - хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлсэн<br>0 - хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж | 1<br>15 | 1<br>15 | 1<br>15 | Засгийн газрын 13 Засгийн газрын 13 гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга болон Үндэсний хөгжлийн газрын дарга нарын аймгийн Засаг даргатай 2021 онд байгуулсан 15 гэрээний үүргийн биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох дүгнэлт зөвлөмж боловсруулан тайланг 2021 оны 04 сарын 01-ний өдрийн дотор ЗГХЭГ болон яамдуудад гэрээнд туссан хугацаанд хүргүүлсэн.<br>Мөн 2022 онд 17 сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргатай байгуулсан гэрээг хяналтад авч эхний хагас жилийн байдлаар 5 сайдын гэрээний хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ хийж холбогдох | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зөвлөмж хүргүүлээгүй<br>-Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх гэрээний тоо | | | | тайлан зөвлөмж боловсруулан яамдуудад хугацаанд нь хүргүүлсэн. | |
| 6.1.4 | Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж боловсруулах, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх, | - | -Журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хэлтэс, агентлагуудад зөвлөмж хүргүүлсэн эсэх<br>1 - хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлсэн<br>0 - хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөмж хүргүүлээгүй<br>-Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх гэрээний тоо | 1 | 1 | 1 | Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 400 арга хэмжээний хэрэгжилтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд, үр дүнтэй буюу 100 хувьтай арга хэмжээ 185, гол үр дүн нь гарч эхэлж байгаа буюу 90 хувьтай арга хэмжээ 51, гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70 хувьтай арга хэмжээ 57, бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн буюу 50 хувьтай арга хэмжээ 19, бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа буюу 30 хувьтай арга хэмжээ31, хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй “0” хувьтай арга хэмжээ 57, нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 76.4 хувьтай байсан. Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01/197 албан бичгээр ЗГХЭГ-ын ХШҮДАГ-т хугацаанд нь хүргүүлсэн. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, төлөвлөх, боловсруулах, тайлагнахад анхаарах асуудлаар зөвлөмж боловсруулан 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 03/471 дүгээр албан бичгээр аймгийн ЗДТГ-ын 5 хэлтэс, 28 агентлагт хүргүүлсэн бөгөөд зөвлөмжийн биелэлтийг 2022 оны жилийн эцсийн байдлаар агентлагийн жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд дүгнэнэ. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6.1.5 | Аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж боловсруулах, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх | - | -Журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хэлтэс, агентлагуудад зөвлөмж хүргүүлсэн эсэх<br>1 - хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлсэн<br>0 - хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөмж хүргүүлээгүй<br>-Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх гэрээний тоо | 1 | 1 | 1 | Аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний 139 зорилтын 255 арга хэмжээний хэрэгжилтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд арга хэмжээний зорилтот түвшинд бүрэн хүрсэн буюу 100 хувьтай арга хэмжээ 109, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа буюу 90.0 хувьтай арга хэмжээ 39, тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70.0 хувьтай арга хэмжээ 30, бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн буюу 50.0 хувьтай арга хэмжээ 24, бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа буюу 30 хувьтай арга хэмжээ 24, хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй “0” хувьтай арга хэмжээ 29, нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 72.2 хувь байна. Аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01/197 дүгээр албан бичгээр ЗГХЭГ-ын ХШҮДАГ-т хугацаанд нь хүргүүлсэн. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг төлөвлөх, боловсруулах, тайлагнахад анхаарах асуудлын талаар зөвлөмж боловсруулан 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 03/471 дүгээр албан бичгээр аймгийн ЗДТГ-ын 5 хэлтэс, 28 агентлагт хүргүүлсэн бөгөөд зөвлөмжийн биелэлтийг 2022 оны жилийн эцсийн байдлаар агентлагийн жилийн үйл | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд дүгнэнэ. | |
| 6.1.6 | Аймгийн Засаг даргын тамгын газрын төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2021 оны биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх | - | -Журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хэлтэс, агентлагуудад зөвлөмж хүргүүлсэн эсэх<br>1 - хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлсэн<br>0 - хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөмж хүргүүлээгүй<br>-Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх гэрээний тоо | 1 | 1 | 1 | Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн тайлангийн хүний нөөцийг идэвхижүүлэхтэй холбоотой 3 үйл ажиллагааны 8 шалгуур үзүүлэлт, албан хаагчдын нийгмийн баталгааг хангахтай холбоотой 4 үйл ажиллагааны 6 шалгуур үзүүлэлт бүрээр хяналтад авч хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.2, 6.2.3 дахь заалтуудын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг 2022 оны 04 сарын 01-ний өдрийн дотор ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>Мөн МУ-ын ЗГ-ын 2021 оны 374 дүгээр тогтоолын хавсралтаар шинэчлэгдэн батлагдсан шалгуур үзүүлэлтүүдийг хяналтад авсан бөгөөд хэрэгжилтийг дараа оны 04 сарын 01-ны дотор гаргаж холбогдох газарт хүргүүлнэ. | 100 |
| 6.1.7 | Аймгийн Засаг даргын тамгын газрын ил тод байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх | - | -Журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хэлтэс, агентлагуудад зөвлөмж хүргүүлсэн эсэх<br>1 - хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлсэн<br>0 - хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөмж хүргүүлээгүй | 1 | 1 | 1 | Байгууллагын ил тод байдал тайлангийн үйл ажиллагааны ил тод байдал хэсгийн 9 арга хэмжээ, хүний нөөцийн ил тод байдал хэсгийн 5 арга хэмжээг хяналтад авч хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.2, 6.2.3 дахь заалтуудын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг 2022 оны 04 сарын 01-ний өдрийн дотор ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>Мөн МУ-ын ЗГ-ын 2021 оны 374 дүгээр тогтоолын хавсралтаар шинэчлэгдэн батлагдсан шалгуур үзүүлэлтүүдийг хяналтад авсан бөгөөд хэрэгжилтийг дараа оны 04 сарын 01-ны дотор гаргаж холбогдох газарт хүргүүлнэ. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | -Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх гэрээний тоо | | | | | |
| 6.1.8 | Аймгийн Засаг даргын тамгын газрын 2021, 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүнг хэлтсийн дарга нарын хурлаар хэлэлцүүлэх, гарсан дүгнэлт зөвлөмжийг холбогдох нэгжид хүргүүлж биелэлтийг хангуулах | - | -Журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хэлтэс, агентлагуудад зөвлөмж хүргүүлсэн эсэх<br>1 - хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлсэн<br>0 - хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөмж хүргүүлээгүй<br>-Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх гэрээний тоо | 0<br>0 | 1 | 1<br>2 | Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 9 салбар чиглэлийн 71 зорилтын 157 арга хэмжээний хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.2, 6.2.3 дахь заалтуудын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох тайланг 2021 оны 04 сарын 01-ний өдрийн дотор ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>2022 оны хагас жилийн гүйцэтгэлийн тайланд ХШҮ хийж зөвлөмжийг хүргүүлсэн. | 100 |
| 6.1.9 | Аймгийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулах, өгсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавих, үр дүнг тооцож ажиллах | - | -Үүрэг даалгаврыг удирдах ажилтнуудад хүргүүлж биелэлтийг тооцсон эсэх<br>1-биелэлтийг тооцсон<br>0-биелэлтийг тооцоогүй<br>-Зөвлөгөөний тэмдэглэлийн тоо | 1<br>1 | 1<br>6 | 1<br>12 | 2022 оны 1-10 дугаар сард аймгийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 9 удаа зохион байгуулж, аймгийн Засаг даргын зүгээс агентлаг, байгууллагын дарга нарт нийт 61 үүрэг даалгавар өгсөн байна. Цаг үеийн ажил төрлийн байдлаас шалтгаалан 8, 11 дүгээр сард шуурхай зөвлөгөөн зохион байгуулаагүй. Удирдах ажилтны зөвлөгөөний үеэр өгөх үүрэг даалгаврын төслийг бэлтгэн, үүрэг даалгаврыг агентлаг, байгууллагуудад албан бичгээр хүргүүлж, биелэлтийг журмын дагуу тухай бүр нэгтгэж, шуурхай зөвлөгөөний зарыг хүргэж, удирдах ажилтнуудын ирцийг бүртгэн, зөвлөгөөний тэмдэглэлийг хөтөлсөн. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6.1.10 | Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагаанд явцын үнэлгээ хийх, үр дүнг тооцож ажиллах | - | -Явцын үнэлгээний самбарыг хөтлөж үнэлгээ хийсэн эсэх 1-үнэлгээ хийсэн 0-үнэлгээ хийгээгүй -Үнэлгээ хийх үзүүлэлтийн тоо | 1<br>14 | 1<br>14 | 1<br>14 | Аймгийн Засаг даргын 2020 оны 254 дүгээр захирамжаар батлагдсан “Агентлагийн үйл ажиллагаанд явцын үнэлгээ хийх журам”-ын дагуу аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 28 агентлаг, 19 сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны явцын үнэлгээг журамд заасан 12 үзүүлэлтийн дагуу сар, улирал, хагас жилээр хийж, үнэлгээний самбарт тэмдэглэсэн. | 100 |
| 6.1.11 | Сумдын Засаг дарга нартай цахим хурал зохион байгуулах, үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавих, үр дүнг тооцох | - | -Үүрэг даалгаврын биелэлтийг тооцсон эсэх 1-биелэлтийг тооцсон 0-биелэлтийг тооцоогүй -Цахим хурлын тэмдэглэлийн тоо | 1<br>9 | 1<br>6 | 1<br>12 | Аймгийн Засаг дарга ЗДТГ-ын удирдлагуудаас сумдын удирдлагуудтай нийт 5 удаа хуралдаж 41 үүрэг даалгаврыг албан бичгээр хүргүүлж сар бүрийн 22-ны дотор биелэлтийг хүлээн авч үүрэг болгосон заалт тус бүрийн хэрэгжилтийг сум бүрээр үнэлж дараа сарын онлайн хурал дээр хэрэгжилтийг танилцуулж байна. | 70 |
| 6.1.12 | Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумын Засаг дарга, Засаг даргын тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт зөвлөмж хүргүүлэх, мэргэшил арга зүйн зөвлөгөө мэдээллээр хангах | - | -Хяналт-шинжилгээ, үнэлгээний тоо -Зөвлөмжийн тоо | 1<br>2 | 1<br>1 | 2<br>2 | Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 26 агентлагийн 2021 оны жилийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын 2021 оны А/143 дугаар захирамжаар батлагдсан журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн V хуралдаанд танилцуулж, 2021 онд амжилттай сайн ажилласан 5 агентлагийг “Өргөмжлөл”-өөр, агентлагийн даргыг 1 сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллаар шагнуулахаар шийдвэрлүүлж, 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр “Өргөмжлөл”, захирамжийг гардуулж шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажилласан. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн 2021 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 03/471 дүгээр албан | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бичгээр 26 агентлагт хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Мөн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах зорилгоор гүйцэтгэл сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах чиглэлийг агентлагуудад хүргүүлсэн. Агентлагуудын 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайланг 06 дугаар сарын 15-ны дотор хүлээн авч, хяналт-шинжилгээ хийж, цаашид анхаарах чиглэлээр зөвлөмж боловсруулан 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 03/1266 албан бичгээр хүргүүлсэн.<br><br>Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 28 агентлагийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод ажил, хүний нөөц, тайлан мэдээ хариуцсан албан хаагчдад тухай бүр утсаар болон биечлэн мэргэшил арга зүйн зөвлөгөө өгч, холбогдох мэдээ мэдээллээр тухай бүр ханган ажиллаж байна. Мөн ажлын уялдаа холбоог сайжруулах зорилгоор “Архангай аймгийн ХШҮХ” группээр дамжуулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчдад холбогдох мэдээ мэдээллийг тухай бүр хүргэж байна. “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж, нэмэлт өөрчлөлт нь 2022 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан “Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумын Засаг дарга, ЗДТГ-ын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-д аймгийн Засаг даргын 2022 оны А/394 дүгээр захирамжаар нэмэлт, өөрчлөлт оруулан, журмыг товхимол болгон хэвлүүлж 7-р | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сарын 22-ны өдрийн 09/1267 албан бичгээр 28 агентлагт хүргүүлсэн. Агентлагийн 2022 оны жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна. Аймгийн Засаг даргын тамгын газар НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн “Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь-Ensure” төсөлтэй хамтран аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлаг, төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ, хүний нөөц хариуцсан албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгууллаа. Энэхүү сургалтад 69 төрийн албан хаагчийг хамруулж Төрийн албаны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт, төрийн албан хаагчийн ёс зүй, агентлаг, сумдын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах, бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналтад анхаарах асуудал зэрэг сэдвээр мэдээлэл өгсөн. | |
| ДОЛОО. БАТЛАН ХАМГААЛАХ ТАЛААР | | | | | | | | |
| АХЖТ-ний 4.3. Гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулахад төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, батлан хамгаалах хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангана. | | | | | | | | |
| **Зорилт 7.1** | **Батлан хамгаалах бодлого үйл ажиллагаа орон нутагт хэрэгжүүлэх** | | Үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлсэн эсэх | Тийм | Тийм | Тийм | I-IV улирал | **100** |
| 7.1.1 | Батлан хамгаалах газрын дайчилгаа удирдах бүлгийн гишүүд цугларах, техник шилжүүлэх байруудын томилгоот бүрэлдэхүүнтэй явуулах сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх | 17.650.0 | -Дайчилгааны бэлэн байдлыг дээшлүүлж материаллаг баазыг бүрдүүлсэн эсэх | Тийм | Тийм | Тийм | Дайчилгааны бэлэн байдлыг дээшлүүлж материаллаг баазыг бэхжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөсөн боловч аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн 2022 оны төсвийн тодотголын хурлаар дайчилгааны сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх төсөв хөрөнгийг шийдэж өгөөгүй. | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7.1.2 | Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс, Батлан хамгаалах тухай, Зэвсэгт хүчний тухай, Дайны байдлын тухай, Цэргийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиудыг нийт ард иргэдэд сурталчлан таниулж иргэдтэй эх оронч үзэл, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллана | - | -Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс, Батлан хамгаалах тухай, Зэвсэгт хүчний тухай, Дайны байдлын тухай, Цэргийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиудыг нийт ард иргэдэд сурталчилсан тоо<br>-Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх чиглэлээр хамтран ажилласан тоо | 5<br>1 | 4<br>1 | 10<br>1 | Батлан хамгаалахын хууль тогтоомжийн эмхтгэл, цэргийн бүртгэлийг сум, багт зохион байгуулах заавар, хугацаат цэргийн алба, цэргийн гэрээт алба, цэргийн дүйцүүлэх алба, цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах, цэргийн бүртгэл, “Оюутан-цэрэг”-ийн хөтөлбөр сургалтын талаар ард иргэдэд сурталчлах зорилгоор танилцуулах, тараах материалуудыг бэлтгэн хэвлүүлж тараасан. Мөн цахим сүлжээ, олон нийтийн мэдээлэлийн хэрэгсэл, аймгийн “АВ”, “Тамир” телевиз, Архангайн толь, Архангайн амьдрал гэсэн сонин, хэвлэл мэдээллээр хууль сурталчлах ажлыг үе шаттайгаар зохион байгууллаа.<br>Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчдын дархлааг дэмжих зорилгоор витамин, дархлаа дэмжих бүтээгдэхүүн, алба хаагчдын хэрэгцээнд шаардагдах индүү, үсний машин ус буцалгагч зэргийг худалдан авч өгсөн. | 100 |
| 7.1.3 | Өсвөр ирээдүй, хойч үеийг эх орноо хайрлах, эх оронч хүмүүжлээр төлөвшүүлэх | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 0 | 1 | 1 | Эрдэнэбулган сумын 1,3 дугаар багийн Засаг дарга нартай хамтран Ерөнхий боловсролын Лаборатори нэгдүгээр сургууль, Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн ахлах ангийн сурагчдад цэргийн албаны хууль тогтоомж, тушаал шийдвэрийг сурталчлан таниулах зорилгоор сургалт зохион байгуулсан тус сургалтад нийт 95 сурагч хамрагдсан дараагийн сургалтыг 2,4 дүгээр багийн Засаг даргатай хамтран Ерөнхий боловсролын 2, 5 дугаар сургууль дээр зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | 100 |
| 7.1.4 | Иргэнийг тайван цагт цэргийн жинхэнэ албанд тэнцүүлэхэд эрүүл мэндийн байдлыг тодорхойлж, дүгнэлт | - | Хамрагдсан сумдын тоо | 19 | 19 | 19 | 2022 онд аймгийн цэрэг татлагын комиссын хурлаар цэргийн насны болон эрүүл мэндийн заалтаар хасагдсан иргэдийг эрүүлжүүлэх ажлыг хэлэлцэж тусгай төлөвлөгөө гаргаж 2022 оны нэг, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | гаргах, эрүүлжүүлэх ажилд хамтран ажиллах | | | | | | хоёрдугаар ээлжээр эрүүл мэндийн үзлэгээр орж түүнээс эрүүл мэндийн заалтаар хасагдсан 687 иргэн үүнээс 229 иргэнийг аймгийн Эрүүл мэндийн газар болон сумдын эрүүл мэндийн төвтэй хамтран 100 гаруй иргэнд эрүүл мэндийн үзлэг хийж эрүүлжүүлэх ажлыг хийгээд байна. | |

---o0o---